



БАЯН-ӨНДӨР СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРЛЫН ТОГТООЛ



ЭРДЭНЭТ ХОТ
2014 ОН

ГАРЧИГ

ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2014 ОН

ЭЭЛЖИТ VIII ХУРАЛДААН /2014.01.28/

№02. Сумын 2014 оны хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр арга хэмжээний жагсаалт батлах тухай.....	4
№03. Сум хөгжүүлэх сангийн тэргүүлэх чиглэл,дотоод журмыг шинэчлэн батлах тухай.....	7
№04. Сум хөгжүүлэх сангийн 2014 оны үйл ажиллагааны төсөв батлах тухай.....	12
№05. Үндсэн чиглэлд өөрчлөлт оруулах тухай.....	13
№06. Чанарын удирдлагын тогтолцооны ISO 9001 олон улсын стандарт нэвтрүүлэх тухай.....	21

ЭЭЛЖИТ IX ХУРАЛДААН /2014.04.25/

№02. Малчин багийг Жаргалант суманд шилжүүлэх тухай.....	22
№03. Сумын Засаг даргын нөөц хөрөнгө зарцуулах, хяналт тавих журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай.....	23
№04. Журам батлах тухай.....	26

ЭЭЛЖИТ X ХУРАЛДААН /2014.06.06/

№02. 2014 оны ОНХС-ийн төсвөөс санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний жагсаалтад тодотгол хийх тухай.....	30
--	----

ЭЭЛЖИТ XI ХУРАЛДААН /2014.08.06/

№02. Тогтоолын хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулах тухай.....	31
№03. Гэр хорооллын хаягжуулалтыг шинэчлэн тогтоох тухай.....	32
№04. Багуудын хилийн цэсийг шинэчлэн тогтоох тухай	33

ЭЭЛЖИТ XII ХУРАЛДААН /2014.10.24/

№02. Төлөөлөгчийн бүрэн эрхийг зөвшөөрөх тухай	39
№03. Сумын нутаг дэвсгэрт 2015 онд ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөтөлбөр	
№04. төсөл арга хэмжээг эрэмбэлэх тухай.....	40
№05. Ойн нөхөрлөлүүдийн мэдээлэл сонссон тухай	43

ЭЭЛЖИТ XIII ХУРАЛДААН /2014.12.12/

№02. 2014 оны үндсэн чиглэлийн биелэлтийн тухай.....	44
№03. Сумын эдийн засаг нийгмийг 2015 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг батлах тухай.....	45

№04. Баян-Өндөр сумын 2015 оны төсөв батлах тухай.....	72
№05. Сум хөгжүүлэх сангийн тэргүүлэх чиглэл, дотоод журмыг шинэчлэн батлах тухай.....	76
№06. Сум хөгжүүлэх сангийн 2014 оны үйл ажиллагааг үнэлэх, 2015 оны үйл ажиллагааны төсөв батлах тухай	84
№07. 2014 оны ОНХС-ийн төсвөөс санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний жагсаалтад нэмэлт тодотгол оруулах тухай	87

ЭЭЛЖИТ ХІV ХУРАЛДААН /2014.12.30/

№02. Сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөө батлах тухай.....	88
№03. Сумын амьжиргааг дэмжих зөвлөлөөс 2014 онд зохион байгуулсан ажилд үнэлэлт өгөх тухай.....	95
№04. Байгаль орчныг хамгаалах ажлын 2014 оны ажлын хэрэгжилтэд үнэлэлт өгөх тухай.....	96
№05. Баян-өндөр сумын 2014 оны ОНХС-гийн төсөвт тодотгол хийх тухай.....	97
№06. ИТХ-ын үйл ажиллагааны 2014 оны төлөвлөгөөний биелэлтэд үнэлэлт өгөх тухай.....	98
№07. ИТХ-ын үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх 2015 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах тухай	99

ЭЭЛЖИТ БУС II ХУРАЛДААН /2014.06.30/

№02. Баян-Өндөр сумын 2014 оны тодотгосон төсөв батлах тухай.....	116
№03. Сумын 2014 оны ОНХС-гийн төсөвт тодотгол хийх тухай	120
№04. Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай	123
№05. Сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагааны төсвийг шинэчлэн батлах тухай ...	124

ЭЭЛЖИТ БУС III ХУРАЛДААН /2014.09.19/

№02. 2014 оны ОНХС-гийн хөрөнгө оруулалт, хөтөлбөр төсөл арга хэмжээний жагсаалтад тодотгол, нэмэлт өөрчлөлт оруулах тухай.....	125
№03. Санал асуулгын хуудасны загвар батлах тухай.....	126



**ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 6 ДАХЬ УДААГИЙН
СОНГУУЛИЙН ЭЭЛЖИТ VIII ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2014 оны 01 сарын 28 өдөр

Дугаар 02

Эрдэнэт

Сумын 2014 оны хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр
арга хэмжээний жагсаалт батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.2 дахь заалтыг үндэслэн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ээлжит VIII хуралдаанаар хэлэлцээд ТОГТООХ нь:

1.Сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2014 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээ төсвийн жагсаалтыг I хавсралтаар баталсугай.

2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөтөлбөр төсөл арга хэмжээг батлагдсан төсөвт багтаан хуулийн дагуу зарцуулж, гүйцэтгэлийг хагас жилээр Тэргүүлэгчдийн, бүтэн жилээр хурлын хуралдаанд танилцуулахыг сумын Засаг дарга /И.Баасанжав/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Н.ЖАРГАЛСАЙХАН

Сумын ИТХ-ын 2014 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн
VIII дугаар хуралдааны 01 дүгээр тогтоолын хавсралт

Баян-Өндөр сумын 2014 оны хөгжлийн сангийн төсвөөс санхүүжих хөрөнгө оруулалт төсөл арга хэмжээний жагсаалт

д/д	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	СИТХ-аар батлуулах санал	ӨӨРЧ ЛӨЛТ	СИТХ-аар баталсан
1	Засаг дарга	4 407 300,00	-	4 407 300,00
1,1	Хөрөнгө оруулалт	4 407 300,00	-	4 407 300,00
Шилжих хөрөнгө оруулалт		408 200,00	-	408 200,00
1.1.1	2013, 2014 онуудад хийх ажлуудын зураг төсвийн зардал	208 590,30		208 590,30
1.1.2	Гэр хорооллын цахилгаан хангамжийг нэмэгдүүлэх ажил	199 609,70		199 609,70
1.1.3				-
Шинээр эхлэх хөрөнгө оруулалт		2 886 592,40	-	2 886 592,40
1.1.4	Орон сууцны 1-2-6, 1-12-1, 1-13-3 -р блокийн дээвэр	64 834,20		64 834,20
1.1.5	Орон сууцны 2-1а-2, 2-4-3, 2-13-1-р блокийн дээвэр	67 894,40		67 894,40
1.1.6	Орон сууцны 3-6-6, 3-8-4, 3-9-5-р блокийн дээвэр	71 818,10		71 818,10
1.1.7	Орон сууцны 4-6-2, 4-27-1 ,4-5-2-р блокийн дээвэр	75 816,20		75 816,20
1.1.8	Орон сууцны 5-1-3 ,5-13-5, 5-14-2-р блокийн дээвэр	68 559,60		68 559,60
1.1.9	Орон сууцны 6-18-2, 6-11-4, Дэнж СӨХ 2-2-р блокийн дээвэр	68 000,10		68 000,10
1.1.10	Орон сууцны 5-24-1, 2-3-2, 3-23-2 -р блокийн дээвэр	76 710,10		76 710,10
1.1.11	Орон сууцны 3-22-3, 3-11-3, 3-24-1-р блокийн дээвэр	64 366,60		64 366,60
1.1.12	Орон сууцны 3-20-2, 5-18-5, Дэнж СӨХ 2-1-р блокийн дээвэр	69 675,90		69 675,90
1.1.13	Орон сууцны 4-16-1, 5-14-3, 6-13-1-р блокийн дээвэр	76 229,80		76 229,80
1.1.14	Орон сууцны 4-25-2, 4-14-2, 4-9-2 -р блокийн дээвэр	76 639,50		76 639,50
1.1.15	Орон сууцны Зэст багийн 1-12, 1-13,Баянцагаан багийн төмөр зам 3,4,Оюут багийн 2-22.2-161.2.3-р болк,2-23 ,Уурхайчин багийн 3-11,3-9-р байруудын заадас	71 619,10		71 619,10
1.1.16	Орон сууцны Уурхайчин багийн 3-17, 3-24, Хүрэнбулаг багийн 4-6, 4-14, 4-23-1.2, 4-22-1, 2-р блок Уртбулаг багийн 5-1, 5-19-р байруудын заадас	76 237,30		76 237,30
1.1.17	Орон сууцны Уртбулаг багийн 5-21,5-24,Бүрэнбүст багийн 5-6,5-7,5-11,5-12, Согоот багийн 6-9-р байруудын заадас	69 368,80		69 368,80
1.1.18	Орон сууцны Согоот багийн 6-9,6-12,6-16,Дэнж багийн СӨХ 1, СӨХ 2-1.2.3-р блок байруудын заадас	34 622,70		34 622,70
1.1.19	Хотын камержуулалтын ажил	200 000,00		200 000,00
1.1.20	Гэр хорооллын багуудын гэрлэн хаягийг засварлах	40 200,00		40 200,00
1.1.21	Дэнж багийн гудамжны гэрэлтүүлэг	197 000,00		197 000,00
1.1.22	Эрдэнэ багийн гудамжны гэрэлтүүлэг	297 000,00		297 000,00
1.1.23	Шанд багийн гудамжны гэрэлтүүлэг	71 000,00		71 000,00
1.1.24	Баянцагаан багийн гудамжны гэрэлтүүлэг	150 000,00		150 000,00

1.1.25	Говил багийн гудамжны гэрэлтүүлэг	85 000,00		85 000,00
1.1.26	Амралт чөлөөт цагийн талбай байгуулах /ТЗ-2-р байр, 11, 20, 23-р цэцэрлэг, Наран 26-6, 5-12.13-р байр хооронд/	282 536,70		282 536,70
1.1.27	Зэст багийн Оюу цэцэрлэг, Оюут багийн Дэгдээхэй цэцэрлэг, Уурхайчин баг 6.7-р, Хүрэнбулаг баг 5.6.7, Согоот баг 5.6 байр хооронд	217 463,30		217 463,30
1.1.28	Зэст, Оюут, Уурхайчин, Дэнж, Булаг, Говил багуудад нийтийн хогийн цэг байгуулах	24 000,00		24 000,00
1.1.29	"Цахим сум" хөтөлбөрийн зардал	250 000,00		250 000,00
1.1.30	Иргэд хүлээн авах танхимын зардал	20 000,00		20 000,00
1.1.31	Wi-Fi талбай байгуулах зардал	20 000,00		20 000,00
1.2.	Тоног төхөөрөмж	230 000,00	-	230 000,00
1.2.1	Орон сууцны байруудын орцыг кодтой хаалгаар солих /Оюут баг: 22,24,25,26,27-р байрнуудын 10 орц, Уурхайчин баг: 2,3,6,16,17,19,20,22,23,24 байрнуудын 52 орц, Уртбулаг баг: 1,2,3,4,5,19,20,21,23-р байрнуудын 40 орц/ нийт 102 орц	50 000,00		50 000,00
1.2.2	Гэр хорооллын багуудад хогны автомашин худалдан авах /Наран, Булаг, Рашаант, Цагаанчулуут/	120 000,00		120 000,00
1.2.3	Жижиг амьтны эмнэлэг, үйлчилгээний нэгж байгуулах зардал / тоног төхөөрөмж худалдан авах/	10 000,00		10 000,00
1.2.4	Золбин муур, нохой устгахад зориулан үйлчилгээний авто машин авах зардал	10 000,00		10 000,00
1.2.5	Хадлангийн иж бүрдэл / бага оврын троктар, хадуур, тармуур/	5 500,00		5 500,00
1.2.6	Пресс / хаман боогч /	12 000,00		12 000,00
1.2.7	Хүлэмж / 6х20/	4 000,00		4 000,00
1.2.8	Төрөл бүрийн суулгац	8 500,00		8 500,00
1.2.9	Гүний худгийн цахилгаан хангамж /Баянцагаан баг/	10 000,00		10 000,00
1.3.	Их засвар	100 067,80	-	100 067,80
1.3.1.	Орон сууцны байруудын сантехникийн засвар	50 000,00		50 000,00
1.3.2.	Зэст багийн 1,2,3,4,-р байруудын хаяавчны засвар	50 067,80		50 067,80
1,4	Зураг төсөв	61 900,00	-	61 900,00
1.4.1	2014 оны хөрөнгө оруулалтын ажлын зураг төсөв боловсруулах	61 900,00		61 900,00
1,5	Бусад зардал	720 539,80	-	720 539,80
1.5.1	Сумын баяр наадмын зардал	5 000,00		5 000,00
1.5.2	Эр нохойг засах, эм нохойны өндгөвч авах, золбин нохойг устгах ажлын зардал	153 400,00		153 400,00
1.5.3	Мал эмнэлгийн нэгдсэн арга хэмжээний зардал /үхрийн люкоз тарилга хийх/	10 000,00		10 000,00
1.5.4	Хуваарилагдаагүй зардал	552 139,80		552 139,80



**ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 6 ДАХЬ УДААГИЙН
СОНГУУЛИЙН ЭЭЛЖИТ VIII ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2014 оны 01 сарын 28 өдөр

Дугаар 03

Эрдэнэт

Сум хөгжүүлэх сангийн тэргүүлэх чиглэл,
дотоод журмыг шинэчлэн батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 дахь заалт, Засгийн газрын 2011 оны 134 дүгээр тогтоолын I зүйлийн 1.6 дахь заалт, 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх заалтыг үндэслэн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ээлжит VIII хуралдаанаар хэлэлцээд ТОГТООХ нь:

1.Сум хөгжүүлэх сангийн хөрөнгөөр зээл олгохтой холбогдуулан сумын хөгжлийн тэргүүлэх чиглэлийг I хавсралтаар, дотоод журмыг шинэчлэн II хавсралтаар тус тус баталсугай.

2.Тогтоолыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, гүйцэтгэлийг жилийн эцэст хурлын хуралдаанд тайлагнахыг сумын Засаг дарга /И.Баасанжав/-д үүрэг болгосугай.

3.Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан хурлын 2013 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 08 дугаар тогтоолыг хүчингүй болгосонд тооцсугай.

ДАРГА

Н.ЖАРГАЛСАЙХАН

2014 оны “Сум хөгжүүлэх сан”-гийн тэргүүлэх чиглэл

“Сум хөгжүүлэх сан”-аас 2014 онд зээл олгоход баримтлах тэргүүлэх чиглэлээ тогтооход 2014 оны аймаг, сумын үндсэн чиглэл, аймгийн статистик мэдээ, Хөдөлмөрийн хэлтэс, ХХААЖДҮ-ийн газар, Барилга хот байгуулалтын газруудаас судалгаа авсны үндсэн дээр дараах чиглэлүүдээр санал оруулж байна.

1. Хүнс, хөдөө аж ахуйн чиглэлийн хүрээнд: Эрчимжсэн мал аж ахуй, тахиа, гахайн аж ахуй, жимс жимсгэний тариалалт, малын тэжээлийн тариалалт, өвлийн хүлэмж, “Эрдэнэт” хотын шинж чанарыг тусгасан брэнд бүтээгдэхүүн
2. Боловсруулах үйлдвэрлэл: Гурил тэжээлийн үйлдвэр, жимс, чацаргана боловсруулах үйлдвэрлэл, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, мал болон нохойн арьс боловсруулах үйлдвэр, бордоо үйлдвэрлэл, оёдол, сүлжмэл, арьс ширэн бүтээгдэхүүн , импорт орлох гутал үйлдвэрлэл, талх нарийн боовны үйлдвэрлэл, хүнсний зориулалттай байгальд ээлтэй уутны үйлдвэрлэл, мод модон бүтээгдэхүүний үйлдвэрлэл
3. Барилгын материал үйлдвэрлэл: Цутгамал бетон зуурмаг, шахмал түлш, хөнгөн блок, дулаалгын материал үйлдвэрлэл, төмөрлөгийн үйлдвэрлэл, хуванцарын үйлдвэрлэл/ замын хашаа, гудамны сандал г.м/ -хог хаягдал ашиглан
4. Боловсролын чиглэлээр: Цэцэрлэгүүдийн сургалтын хэрэгсэл, тоглоомын үйлдвэрлэл, хүүхдийн өдөр өнжүүлэх үйлчилгээ, гэр цэцэрлэг
5. Эрүүл мэндийн чиглэлээр: Хүүхэд, өндөр настны эмнэлэг, сувилал
6. Гэр хорооллын алслагдсан багуудад нийтийн ахуйн үйлчилгээ

БАЯН-ӨНДӨР СУМЫН СУМ ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН ДОТООД ЖУРАМ

1. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү журам нь суманд жижиг, дунд үйлдвэр, хоршоог хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх зорилгоор Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавихтай холбоотой үүссэн харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Сан нь төрийн санд тусгай данстай байх бөгөөд гадуур данстай байхыг хориглоно.
- 1.3. Сангийн орлого зарлага нь сумын төсвийн гүйцэтгэлийн сар бүрийн мэдээ улирал жилийн тайлан тэнцэлд тусгагдана.
- 1.4. Иргэн, жижиг дунд үйлдвэр эрхлэгчдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх зорилго бүхий сум хөгжүүлэх сангаас олгох хөнгөлөлттэй зээл нь дараах нөхцөлтэй байна.
 - 1.4.1 Хөнгөлөлттэй зээлийн хүүгийн хэмжээ жилд 2,8 хувь
 - 1.4.2 Зээлийн хугацаа нь 36 сар хүртэл
 - 1.4.3 Нэг төсөлд олгох зээлийн дээд хэмжээ 10 сая төгрөг хүртэл
 - 1.4.4 Зээлдэгч зээлийг хугацаандаа төлөөгүй, эсвэл зээлийн хөрөнгийн зориулалт бусаар зарцуулсан бол зээлийн төлөгдөөгүй үлдэгдэлд торгууль ногдуулж төлүүлнэ. Торгуулийн хувь хэмжээг зээлийн төлөгдөөгүй үлдэгдэлд хоногийн 0,1% - аар тооцож, дансанд төвлөрүүлж, зээлийн эх үүсвэрт зарцуулна.
 - 1.4.5 Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сан, өрхийн үйлдвэрлэлийг дэмжих сан, сум хөгжүүлэх сангаас урьд авсан зээлийн өргүй, арилжааны банк, бусад санхүүгийн байгууллагад бизнесийн зээлийн өргүй байх, цалин, тэтгэвэр, санхүүгийн түрээс гэх мэт бусад зээлийн үлдэгдэл нь хүсэж буй зээлийн 50%-иас дээшгүй байх
 - 1.4.6 Зээлийг олгохдоо зээлдэгчтэй зээлийн гэрээ болон барьцааны гэрээ, баталгааны гэрээ байгуулан олгох
 - 1.4.7 Зээлийн хэмжээнд тохирсон хөрөнгийг барьцаалах
 - 1.4.8 Тухайн зээлдэгч өөрийн барьцаалах хөрөнгө байхгүй тохиолдолд гуравдагч этгээдийн үл хөдлөх хөрөнгийг хууль тогтоомжийн дагуу барьцаанд тавьж болно.
- 1.5. Сум хөгжүүлэх сангийн төсөл сонгон шалгаруулах зөвлөл нь дараах бүрэлдэхүүнтэй байна.
 - 1.5.1 Зөвлөлийн ахлагч – Сумын Засаг дарга
 - 1.5.2 Зөвлөлийн гишүүд нь сумын ЗДТГ –ын 3 мэргэжилтэн, тухайн сумын 3 иргэний төлөөлөл байна.
 - 1.5.3 Зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт орсон тохиолдолд сонгон шалгаруулалт хийж , сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлж батлуулна.
 - 1.5.4 Зөвлөл нь Сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагааны нягтлан бодох бүртгэлийг хууль тогтоомжийн дагуу хөтөлж, санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан гаргах, сангийн хөрөнгийн зарцуулалт, ашиглалт, зээлийн эргэн төлөлттэй холбоотой мэдээлэл гаргах, хяналт тавих, төрийн сантай харилцах ажлыг хариуцсан нягтлан бодогчтой байна.

2. Зөвлөлийн удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагаа

- 2.1. Зөвлөлийн ахлагч сангийн үйл ажиллагаатай холбогдсон дараах эрх үүргийг хэрэгжүүлнэ.

- 2.1.1 Зөвлөлөөс шалгаруулсан төсөлд зээл олгох шийдвэр гаргах
- 2.1.2 Төсөл нь шалгарсан иргэн аж ахуйн нэгжтэй зээлийн гэрээ байгуулж, гэрээний биелэлтийг хангуулах ажил зохион байгуулж, хэрэгжилтийн явц үр дүнд байнгын хяналт тавьж ажиллах
- 2.1.3 Зээлийн хүүгийн орлогоос зээлийн ашиглалт, эргэн төлөлтөд хяналт тавих үйл ажиллагаанд зарцуулах хөрөнгийн төсвийг боловсруулж иргэдийн төлөөлөгчийн хурлаар хэлэлцүүлэн, сумын жил бүрийн төсөвтэй хамт батлуулах
- 2.1.4 Сангийн үйл ажиллагааны үр дүнг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын өмнө хариуцах
- 2.1.5 Багийн Засаг дарга нарыг үүрэгжүүлэх
- 2.2. Зөвлөлийн нарийн бичиг сангийн үйл ажиллагаатай холбогдсон дараах эрх үүргийг хэрэгжүүлнэ.
 - 2.2.1 Өргөдлийн маягтыг хүлээн авч бүртгэлжүүлэх
 - 2.2.2 Сангийн хөрөнгийн зарцуулалт, ашиглалт, зээлийн эргэн төлөлттэй холбоотой мэдээллийг сар бүрийн 5-ны дотор гаргаж аймгийн Хөдөлмөрийн хэлтэст хүргүүлэх
 - 2.2.3 Зээлдэгчийн талаар гаргасан багуудын төрөлжсөн судалгааны дагуу айл өрх, аж ахуй нэгжээр биечлэн орж, мэдээний үнэн бодит байдалд хяналт тавих
 - 2.2.4 Төсөл нь тэнцээгүй иргэдэд хариуг бичгээр хүргүүлж, тайлбар хийх
 - 2.2.5 Өргөдлийн хариуг багийн Засаг даргаар дамжуулан хүргүүлэх
 - 2.2.6 Зөвлөлийн хурлын тэмдэглэлийг хөтөлж, баримтжуулах
- 2.3. Зөвлөлийн гишүүд сангийн үйл ажиллагаатай холбогдсон дараах эрх үүргийг хэрэгжүүлнэ.
 - 2.3.1 Зөвлөлийн гишүүд нь өргөдөл, төслүүдийг хүлээн авч газар дээр нь очиж танилцан, үнэлгээ хийх.
 - 2.3.2 Улс, орон нутгийн бодлого, чиглэлд уялдуулан сонгон шалгаруулалтыг хийх
 - 2.3.3 Зөвлөлийн гишүүн нь ашиг сонирхолын зөрчилтэй гэж үзвэл санал өгөхөөс татгалзах эрхтэй.
 - 2.3.4 Зээлийн эргэн төлөлт хүндэрч хэвийн бус ангилалд шилжсэн тохиолдолд зөвлөлийн гишүүдийг зээл эргэн төлүүлэх арга ажиллагаанд татан оролцуулна.
- 2.4 Багуудын ажлын алба сангийн үйл ажиллагаатай холбогдсон дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ.
 - 2.4.1 Багийн нийгмийн ажилтан сумын нарийн бичгийн хүлээлгэн өгсөн өргөдлийн маягтыг бодит байдал дээр нь очиж судалж, маягт дахь хэсэгт тодорхойлолтыг бичих
 - 2.4.2 Багийн Засаг дарга тодорхойлолттой танилцаж үнэн бодитой эсэхийг тамга тэмдэгээр баталгаажуулан зөвлөлийн нарийн бичигт хүргүүлнэ.
 - 2.4.3 Сангаас зээл авсан иргэн, аж ахуй нэгжүүдэд багийн нийгмийн ажилтан хяналт тавьж, тухай бүр зээлдэгчийн судалгааг гаргаж зөвлөлийн нарийн бичигт хүргүүлж байх
 - 2.4.4 Төсөл сонгон шалгаруулах хуралд тухайн зээлдэгчийн харъяалагдах багийн нийгмийн ажилтан ирж тухайн зээлдэгчийн үйл ажиллагааг тодорхойлох

3. Төсөл сонгон шалгаруулах

- 3.1. Төсөл сонгон шалгаруулах зөвлөл нь Засгийн газрын 2011 оны 134 дүгээр тогтоолоор баталсан Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журмын 4 дүгээр зүйлийг баримтлан ажиллана.
- 3.2. Хөрөнгийн эх үүсвэрээс шалтгаалан хүлээн авах өргөдөлийн тоог зөвлөлийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэнэ.
- 3.3. Төсөл сонгон шалгаруулах зөвлөл нь дараах үе шаттайгаар төслийг сонгон шалгаруулна.
 - 3.3.1 Өргөдлийг маягтыг зөвлөлийн нарийн бичиг иргэн, аж ахуйн нэгжээс хүлээн авах, шаардлага хангахгүй өргөдлийг өргөдөл гаргагчид буцаах,

- 3.3.2 Зөвлөлийн гишүүд өргөдлийн маягттай танилцаж, харъяа багийн Засаг дарга нарт хүлээлгэн өгч тодорхойлолт гаргуулах
- 3.3.3 Тодорхойлолт гаргасан өргөдлүүдийг зөвлөлийн хурлаар дахин хэлэлцэж үнэлгээ хийж, төсөл ирүүлэх иргэн, аж ахуйн нэгжийг тодруулах
- 3.3.4 Зөвлөлийн гишүүд танилцсан төслүүдийг хурлаар хэлэлцүүлэн олонхийн саналаар сонгон шалгаруулана.
- 3.3.5 Шалгарсан төслүүдэд сумын Засаг дарга захирамж гарган, зээлдэгчтэй зээлийн гэрээ барьцааны гэрээ болон баталгааны гэрээ байгуулан зээлийг олгоно.

3.4 Олонхийн санал авсан төсөл гэдэгт ирцийн 60% ба түүнээс дээш гишүүдийн санал авсан төслийг хамааруулж ойлгоно.

3.4 Төсөл сонгон шалгаруулах хурлыг гишүүдийн 71% хувийн ирцтэй тохиолдолд хийнэ.

3.5 Төсөл сонгон шалгаруулах зөвлөл нь сангаас зээл хүссэн иргэн аж ахуйн нэгжийн боловсруулсан төслийг сонгон шалгаруулахдаа дараах шалгуурыг харгалзан үзнэ.

3.5.4 Сумын ИТХ –с баталсан сумын хөгжлийн тэргүүлэх чиглэлд нийцсэн байх

3.5.5 Тухайн суманд жижиг, дунд үйлдвэрлэл хөгжүүлэх бодлогын хүрээнд орон нутгийн давуу талд түшиглэсэн үйлдвэрлэл, үйлчилгээг бий болгох, орон нутагт тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэхэд чиглэгдсэн байх

3.5.6 Хүрэх үр дүн, зорилт нь тодорхой байх

3.5.7 Төслийн үр ашиг, гэрээний хугацаанд зээлээ эргэн төлөх боломжтой байх

3.5.8 Төслийг хэрэгжүүлэх явцад учирч болзошгүй эрсдэлийг бодитой тодорхойлсон, эрсдэлийг даван туулах талаар тусгасан байх

3.5.9 Ажлын байр нэмэгдүүлэхэд чиглэсэн байх

3.6 Сангийн хөрөнгөөс зээл авч төсөл хэрэгжүүлэх этгээд нь дараах шаардлагыг хангасан байна.

3.6.4 Арилжааны банк болон бусад санхүүгийн байгууллагад бизнесийн зээлийн өргүй байх

3.6.5 Үйл ажиллагаагаа өргөтгөх, нэмэгдүүлэх зорилготой иргэн, аж ахуй нэгжүүд жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчээр бүртгэгдсэн байх.

3.6.6 Зөвлөлийн хурлаар баталсан зээлийн гэрээний 2.6 дах заалтын шалгуур хангасан батлан даагчтай байх

3.6.7 Зээлийн хэмжээнд тохирсон барьцаатай байх.

4. Хариуцлагын тухай

4.1 Батлан даагч нь зээлдэгчийн зээлийн зарцуулалт, нөхөн төлөлт, үйл ажиллагаанд хяналт тавих бөгөөд үүргээ биелүүлээгүй тохиолдолд баталгааны гэрээнд заасны дагуу зээлдэгчийн өмнөөс бүрэн хариуцлага хүлээнэ.

4.2 Зээлдэгч зээлийг үр ашиггүй зарцуулсан эсхүл зээлийн гэрээнд заасан зориулалтын дагуу зарцуулаагүй, зээл, түүний хүүг гэрээний хугацаа хэтрүүлж төлсөн, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй зэрэг тохиолдолд тухайн иргэн, аж ахуй нэгж нь зээлийн гэрээ болон барьцааны гэрээнд заасны дагуу хариуцлага хүлээнэ.

4.3 Сангийн хөрөнгийг зарцуулах зээл олгох, зээлийн хөрөнгийг ашиглах, хяналт тавих, тайлагнах үйл ажиллагааны талаар энэхүү журмаар тогтоосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

oOo



**ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 6 ДАХЬ УДААГИЙН
СОНГУУЛИЙН ЭЭЛЖИТ VII ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2014 оны 01 сарын 28 өдөр

Дугаар 04

Эрдэнэт

**Сум хөгжүүлэх сангийн 2014 оны
үйл ажиллагааны төсөв батлах тухай**

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 дахь заалт, Засгийн газрын 2011 оны 134 дүгээр тогтоолын 1.8 дахь заалт, 3.2.6 дахь заалтыг тус тус үндэслэн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ээлжит VIII хуралдаанаар хэлэлцээд ТОГТООХ нь:

1.Сум хөгжүүлэх сангийн төсөл сонгон шалгаруулах, зээлийн ашиглалт, эргэн төлөлтөнд хяналт тавих ажлыг зохион байгуулах, зөвлөлийн үйл ажиллагаанд 2014 онд зарцуулах төсвийг I хавсралтаар баталсугай.

2.Батлагдсан төсвийг журмын дагуу зарцуулж, санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг хагас, бүтэн жилээр хурлын хуралдаанд тайлагнахыг сумын Засаг дарга /И.Баасанжав/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Н.ЖАРГАЛСАЙХАН



**ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 6 ДАХЬ УДААГИЙН
СОНГУУЛИЙН ЭЭЛЖИТ VIII ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2014 оны 01 сарын 28 өдөр

Дугаар 05

Эрдэнэт

Үндсэн чиглэлд өөрчлөлт оруулах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх заалтыг үндэслэн хуралдаанаар хэлэлцээд **ТОГТООХ нь:**

1.Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2013-2016 онд хэрэгжүүлэх үндсэн чиглэлд нэмэлт өөрчлөлт оруулан I хавсралтаар баталсугай.

2.Төлөөлөгчдөөс гарсан саналыг үндсэн чиглэлд тусган хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж биелэлтийг жилийн эцэст хурлын хуралдаанд тайлагнахыг хурлын дарга /Н.Жаргалсайхан/-д даалгасугай.

ДАРГА

Н.ЖАРГАЛСАЙХАН

Орхон аймгийн Баян-Өндөр сумын
ИТХ-ын ээлжит VIII хуралдааны
05 дугаар тогтоолын 01 дүгээр хавсралт

**БАЯН-ӨНДӨР СУМЫН ИТХ-ЫН 6 ДАХЬ УДААГИЙН СОНГУУЛИЙН БҮРЭН
ЭРХИЙН ХУГАЦААНД ХИЙХ АЖЛЫН ҮНДСЭН ЧИГЛЭЛ**

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь бүрэн эрхийнхээ хугацаанд Монгол улсын Үндсэн хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, бусад хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ нутгийн удирдлагыг төрийн удирдлагатай хослуулан, нийтийн эрх ашгийг хөндсөн аливаа асуудлыг иргэдийн оролцоотойгоор шийдвэрлэх, нийгмийн оюун санаанд хөгжлийг бүтээх уур амьсгалыг бүрдүүлэн, шууд ардчилал, иргэдийн оролцоонд тулгуурласан эрх зүйт ёсыг хэрэгжүүлж, авлига хүнд суртлаас ангид, хөнгөн шуурхай, ил тод, уламжлал шинэчлэлийг хослуулсан бүтээлч засаг захиргаа хөгжих эрх зүйн зөв орчинг бүрдүүлж, дараах чиглэлийг баримтлан ажиллана.

**Нэг. Хууль зүй, хурал, захиргааны бодлого
хэрэгжилтийн чиглэлээр**

1.1. Хурлын байгууллагын бүтэц тогтолцоог оновчтой зохион байгуулж, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Тэргүүлэгчид, хурлын хороо, хурал дахь намын бүлгүүд, Төлөөлөгчид, Ажлын албаны тасралтгүй үйл ажиллагаа явуулах боломжийг хангаж, нутаг дэвсгэрийн хэмжээний эдийн засаг, нийгмийн асуудлыг бие дааж шийдвэрлэнэ.

1.2. Төлөөлөгчдийн төр захиргааны болон эрх зүйн боловсролыг дээшлүүлэх зорилгоор сургалт семинарт хамруулж, гаргасан санал, санаачилгыг бүх талаар нь дэмжин, сонгогдсон тойрогтоо Аймгийн ИТХ-ын Төлөөлөгчидтэй хамтран ажиллах бололцоог бүрдүүлэн ажиллана.

1.3. Сумын ИТХ, Тэргүүлэгчид, хурлын хороод, ажлын алба, Сумын Засаг дарга, ЗДТГ-ын хоорондын хамтын ажиллагаа, уялдаа холбоог сайжруулна.

1.4. Засаг даргын мөрийн хөтөлбөр болон нутаг дэвсгэрийг хөгжүүлэхэд чиглэгдсэн урт богино хугацааны хөтөлбөр төлөвлөгөөг хэтийн зорилттой уялдуулан баталж, хэрэгжүүлэх ажилд бүх талын дэмжлэг үзүүлж ажиллана.

1.5. Сумын ИТХ-ын үйл ажиллагаанд мөрдөх журмуудыг шинэчлэн боловсруулж, хурлын үйл ажиллагааг боловсронгуй болгоно.

1.6. Хурлын болон ЗДТГ-ын ажлын ил тод байдлыг хангаж, цахимжуулах иргэдэд мэдээллийг нээлттэй хүргэх талаар хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллана.

1.7. Сумын эдийн засаг, нийгмийн асуудлыг бие даан шийдвэрлэх бодлогын хүрээнд Сумын ИТХ-ын Тэргүүлэгчид, Хороод, хурал дахь намын бүлгүүд, Төлөөлөгчдөд иргэдээс ирүүлсэн санал хүсэлт, өргөдөл гомдлыг судлан, дүгнэж оновчтой шийдвэрлэж хариу өгөн, биелэлтэнд хяналт тавьж ажиллана.

1.8. Бүх шатанд иргэний танхим нээн ажиллуулж аливаа шийдвэрийг гаргахаасаа өмнө олон нийтэд мэдээлдэг, тэдний санаа бодлыг судалж, хүлээн авдаг, оролцуулдаг, гаргасан шийдвэрийг нийтэд ил тод мэдээлдэг, иргэний оролцооны ардчилсан соёлыг нэвтрүүлнэ.

1.9. Орон нутгийн онцлог, байршил, хүн ам зүйн бодлогод тохирсон дүрэм журмуудыг иргэдийн оролцоотой боловсруулан баталж, дагаж мөрдүүлэх ажлыг эрчимтэй зохион байгуулна.

1.10. Төрийн үйлчилгээний байгууллагуудын менежментийг сайжруулах бодлогыг дэмжиж, захиалгат аудит тогтмол хийлгэн, иргэдээс байнга шүүмжлэлт өртөж байгаа байгууллага, алба хаагчдын үйл ажиллагаанд тэдний эрх ашгийн үүднээс үнэлэлт дүгнэлт өгч хяналт тавих тогтолцоог бий болгоно.

1.11. Сумын ЗДТГ, багуудын бүтэц орон тоо, ажил үүргийн хуваарилалт, ажлын уялдаа холбоог сайжруулах, хүний нөөц, ажилтнуудын мэдлэг ур чадвар хариуцлагыг дээшлүүлэх удирдлага зохион байгуулалтын арга хэмжээг хэрэгжүүлнэ.

1.12. Статистик мэдээллийн үнэ цэнийг өсгөж, удирдлагын хэрэгсэл болгон ажиллах нөхцөл бүрдүүлж ажиллахын зэрэгцээ ил тод байдал, хамрах хүрээг нэмэгдүүлнэ.

1.13. Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын эрх зүйн үндэс болсон хууль тогтоомж, Улсын Их Хурал, Засгийн газар, аймгийн ИТХ-аас гарсан тогтоол шийдвэрийг удирдлага болгон ажилдаа тусгаж, хуулийн төсөл, УИХ, Засгийн газрын бодлого шийдвэрт сумын нутаг дэвсгэрт тулгамдсан тодорхой асуудлуудыг тусгахад онцгой анхаарна.

1.14. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг бүх нийтийн үйл хэрэг болгох, хүүхэд залуучуудад төрийн хуулийг хүндэтгэх, сахин биелүүлэх сэтгэлгээг төлөвшүүлэх, хэв журам сахиулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр гаргасан хөтөлбөрүүдийг төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулж, гэмт хэрэгтэй тэмцдэг олон улсын туршлага, дэвшилтэт арга барилыг нэвтрүүлж, сургалт, сурталчилгааны ажлыг эрчимжүүлнэ.

1.15. Гамшгаас хамгаалах урьдчилан сэргийлэх, болзошгүй гамшиг ослын хор уршгийг арилгах, сэргээн босгох нөөц санг бүрдүүлэх, үйлдвэрлэлийн ослын нөлөөллийг бууруулах ажлыг эрчимжүүлнэ.

Хоёр. Төсөв санхүү, хөрөнгө оруулалтын чиглэлээр

2.1. Сумын төсвийн орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлж, орон нутгийн төсөв, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг хөгжлийн тэргүүлэх чиглэлд оновчтой хуваарилах, хөрөнгө оруулалтын үр ашгийн дээшлүүлэх, хүн амын орлого, нийгмийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх бодлого баримтална.

2.2. Орон нутгийн өмч хөрөнгийн өмчлөгчийн эрхийг хэрэгжүүлэх, нийтийн эзэмшлийн зориулалттай эд хөрөнгийг бүртгэх, хууль тогтоомжид заасан эрхийн дагуу түүнийг эзэмших, ашиглах, захиран зарцуулалтанд хяналт тавьж ажиллана.

2.3. Хөрөнгө оруулалт, тухайн жилд батлагдсан хөтөлбөр төсөл арга хэмжээний хэрэгжилт, орон нутгийн өмчийн ашиглалт хамгаалалт, түүний зарцуулалтын байдалд нийт иргэдийн эрх ашгийн өмнөөс хяналт тавьж, “Төсвийн ил тод байдал”-ыг хангаж ажиллана.

2.4. Сумын хэмжээнд бүх чиглэлээр хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрүүдийн нэгдсэн мэдээллийн сантай болж, үр дүнг тооцох тогтолцоог бий болгоно.

2.5. Сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа томоохон аж ахуйн нэгж, компаниудын салбар сүлжээг орон нутгийн төсөвтэй харьцдаг тогтолцоог бий болгох чиглэл баримтлана.

2.6. Улсын төсөв болон Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тендрийн ил тод байдлыг хангаж, аль болох орон нутгийн аж ахуйн нэгж, байгууллагуудаар гүйцэтгүүлэх бодлого баримтална.

Гурав. Монгол хүн-2020 нийгмийн бодлого, хөгжлийн чиглэлээр

3.1. “Эрх чөлөөтэй, эрдэм боловсролтой, эрүүл чийрэг, ажилтай орлоготой, аюулгүй орчинтой-Монгол хүн” хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлээр иргэдэд мэдээлэл хүргэн үр дүнгийн талаар хэлэлцүүлэг, санал асуулга явуулж, хэрэгжилтэнд хяналт тавина.

3.2. Гэр бүлийн хөгжлийг бүх талаар нь дэмжиж, хүүхэд гэр бүлийн хүрээнд эрүүл саруул өсөн бойжих, хүмүүжих, боловсрол эзэмших амьдралын зөв төлөвшилтэй болох нөхцлийг бүрдүүлэхэд бүх талын дэмжлэг үзүүлнэ.

3.3. Боловсролын тогтолцооны болон сургалтын агуулга, технологийн шинэчлэлийг гүнзгийрүүлэх, сургалтын таатай орчинг бүрдүүлэн, чанар, үр ашиг, хүртээмжийг дээшлүүлэх албан ба албан бус боловсрол олгоход анхаарч ажиллана.

3.4. Ерөнхий боловсролын сургууль, мэргэжил олгох сургалтын байгууллагуудад хичээлээс гадуур хүүхэд залуучуудыг төлөвшүүлэх талаар зохиож буй ажил, хүүхдэд суурь мэдлэг болон мэргэжил олгох талаар зохион байгуулсан ажлыг гол шалгуур үзүүлэлт болгоно.

3.5. Эмзэг бүлгийн өрх, иргэдэд нийгмийн хамгаалал, халамж дэмжлэг үзүүлэх, үйлчилгээг хүртээмжтэй, шударга хүргэхэд болон сум, багийн “Амьжиргааг дэмжих зөвлөл”-ийн үйл ажиллагаанд хяналт тавина.

3.6. Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ая тухтай амьдрах, хөгжих боломжийг нэмэгдүүлэн, нийгмийн орчинг бүрдүүлэх, тэднийг нийгмийн амьдралд бусад иргэдийн адил эрх тэгш оролцох нөхцөл боломжийг хангана.

3.7. Хүүхэд залуучуудад эрүүл амьдралын зөв дадлыг олгох, хорт муу зуршлаас хол байх, тодорхой зорилго тэмүүлэлтэй ажиллаж амьдрах, уламжлалт ёс заншлыг эзэмшүүлэх чиглэлээр ажиллаж буй иргэний нийгмийн байгууллагуудыг бүх талаар дэмжинэ.

3.8. Өрхийн Эрүүл мэндийн төв болон хувийн хэвшлийн эмнэлгүүдийн эмчилгээ үйлчилгээний хүртээмж, чанарыг дээшлүүлэх, өсвөр үе залуучуудад эрүүл мэндийн боловсрол олгох, хүн амын эрүүл мэндийг хамгаалах, халдварт болон халдварын бус өвчлөлөөс урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгааны чанарыг сайжруулахад анхаарна.

3.9. Эм, эмнэлгийн багаж хэрэгслэлийн чанар стандарт, иргэдэд эмээр үйлчлэх үйлчилгээний хүртээмж, жороор олгоход хяналт тавьж, эмийн талаар төрөөс баримтлаж буй бодлогыг дэмжинэ.

3.10. Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, оюутан сурагчдыг нийтийн тээврээр үйлчлүүлэхэд нь хөнгөлөлт эдлүүлэх бодлого баримтлан хэрэгжүүлнэ.

3.11. Соёлын төвүүдийн үйл ажиллагааг эрчимжүүлж, шинээр соёлын төв байгуулахыг дэмжиж ажиллана.

3.12. Хүний хөдөлмөрлөх эрхийг хамгаалж, хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуй, аюулгүй ажиллагаа, үйлдвэрлэлийн эрүүл ахуйн нөхцөл норматив стандартыг мөрдүүлж, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчлөлийг бууруулах чиглэл баримтална.

3.13. Хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээ, ахуйн хэрэглээнд эрүүл ахуй, ариун цэвэр аюулгүй байдлыг ханган, хүн амыг тэжээллэг, чанартай, аюулгүй хүнсээр жигд хүртээмжтэй хангах бодлогыг баримтална.

3.14. Хүн ам зүйн бодлого зохицуулалтанд судалгаа, шинжилгээ хийж, хэтийн төлөвлөлтийг шинжлэх ухааны үндэслэлтэй зохион байгуулна.

3.15. Ажилгүйдэл, ядуурлын одоогийн түвшинд дүн шинжилгээ хийж, ажлын байр нэмэгдүүлэх, бизнес эрхлэх таатай орчин бүрдүүлж, ажилгүйдлийн түвшинг бууруулна.

3.16. Алслагдсан багуудад нийгмийн цогц үйлчилгээг эхний ээлжинд хүргэх бодлого баримтална.

3.17. Нийтийн биеийн тамирыг бүх нийтийн үйлс болгох, хүн амын эрүүл мэндийг хамгаалах, залуу үеийн бие бялдарыг хөгжүүлэхэд чиглэсэн ажлыг дэмжинэ.

Дөрөв. Үйлдвэрлэл, үйлчилгээ, хөдөө аж ахуйн бодлогын чиглэлээр

4.1. Шинэ технологид суурилсан өрсөлдөх чадвартай үйлдвэрлэл үйлчилгээг эрчимтэй хөгжүүлэхэд бүх талаар дэмжлэг үзүүлнэ.

4.2. Жижиг дунд болон өрхийн үйлдвэрлэл, импортыг орлох малын гаралтай түүхий эд, арьс шир, яс, ноос ноолууран бүтээгдэхүүн, жимс жимсгэнэ, хүнсний ногоо боловсруулах зэрэг үйлдвэр байгуулахыг дэмжин ажлын байрыг олноор бий болгоно.

4.3. Нийтийн тээврийн менежментийг сайжруулан шударга өрсөлдөөн бий болгож, такси үйлчилгээний соёл хүртээмжийг дээшлүүлэх бодлого баримтлана.

4.4. Газар тариалан, үрийн аж ахуй, хүнсний үйлдвэрлэлийн бодлогыг дэмжиж, хөрсний үржил шимийг сайжруулах ажлыг эрчимжүүлэх талаар бодлого боловсруулж ажиллана.

4.5. “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”, “Монгол мал”, “Хүнсний аюулгүй байдал” үндэсний хөтөлбөр, малын индексжүүлсэн даатгал, Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, мал эмнэлэг үржлийн үйлчилгээний чадавхийг бэхжүүлэх бодлого баримтална.

4.6. Эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх, малчдын нөхөрлөл хоршоо байгуулах санаачилгыг дэмжих, мэргэжлийн зөвлөгөө өгөх, сурталчлах ажил зохион байгуулна.

4.7. Малчдыг хөдөлмөрөө хоршиж ажиллах, аж ахуйгаа тогтвортой эрхлэн, өргөжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

Тав. Дэд бүтэц, хот тохижилт, байгаль орчин экологийн чиглэлээр

5.1. Сумын эдийн засаг нийгмийг хөгжүүлэх жил бүрийн төлөвлөгөөнд дэд бүтэц барилгажилт, инженерийн байгууламж, гэр хороолол, Эко хорооллын дэд бүтцийг хөгжүүлэх талаар санал боловсруулан тусгаж хэрэгжүүлнэ.

5.2. Орон сууцны байшингийн ашиглалтыг сайжруулах талаар хийж байгаа ажил хөрөнгө оруулалтанд хяналт тавьж, оршин суугчдын ая тухтай амьдрах нөхцөл бүрдүүлэх арга хэмжээг дэмжинэ.

5.3. Үйлдвэрлэл үйлчилгээ, нийгэм соёлын болон нийтийн ариун цэврийн зориулалттай барилга байгууламж барихад дэмжлэг туслалцаа үзүүлнэ.

5.4. Хотын инженерийн байгууламж, цахилгаан хангамж, гэрэлтүүлэг, шугам хоолойн ашиглалтыг сайжруулах, шинээр барихад оруулах хөрөнгө оруулалтыг дэмжинэ.

5.5. Орон нутгийн зориулалттай авто зам гүүр, үерийн далан, ус зайлуулах байгууламжийг орчин үеийн хот тосгонд тавих шаардлагын дагуу, шинээр төлөвлөх, хэрэгжүүлэх бодлого барина.

5.6. Газар зохион байгуулалт, дэд бүтцийг төлөвлөн зохион байгуулж, шинээр үүссэн гэр хорооллуудын цахилгааны болон харилцаа холбооны хүртээмжийг нэмэгдүүлэх бодлогыг дэмжинэ.

5.7. Хог хаягдлын менежментийг боловсронгуй болгон, хот тохижилт, хог цэвэрлэгээний ажилд ААН байгууллага, иргэдийн оролцох оролцоог нэмэгдүүлнэ.

5.8. СӨХ-дын үйл ажиллагааг идэвхижүүлж нийтийн эзэмшлийн талбайн эд хөрөнгийн ашиглалт, гадна орчны тохижилт цэвэрлэгээнд иргэдийн үүрэг оролцоог эрчимжүүлнэ.

5.9. Гэр хорооллын дэд бүтцийг сайжруулахын зэрэгцээ оршин суугчдын дэмжлэгтэйгээр гудамж, хашааг жигдрүүлэн засварлуулах, орчиндоо мод бут тарьж, зүлэгжүүлэлт хийх санаачилгыг дэмжин ажиллана.

5.10. Сумын ногоон бүсийг хамгаалан, нэрэмжит зам талбай, үлгэр жишээ цэцэрлэгт хүрээлэн байгуулах, тэмдэг тэмдэглэгээ, гэрэлтүүлэгтэй зам бариулах арга хэмжээ авна.

5.11. Агаарын бохирдол, хөрс гадаргын усны бохирдол, үйлдвэрлэлийн болон хүний үйл ажиллагаанаас хүрээлэн буй орчинд үзүүлж байгаа хор хохиролыг бууруулах бодлогыг хэрэгжүүлнэ.

5.12. Байгаль орчныг хамгаалах, байгаль цаг уурын гэнэтийн аюулаас урьдчилан сэргийлэх ажилд байгууллага, иргэдийг зөв зохион байгуулж оролцуулах, дээрх чиглэлээр гаргасан санал санаачлагыг бүх талаар дэмжинэ.

ЗУРГАА. Гадаад, дотоод харилцаа хамтын ажиллагааны чиглэлээр

6.1. Гадаад улс орнууд, хотуудтай хуучин харилцаа хамтын ажиллагааг эрчимжүүлэн сэргээж ажиллана.

6.2. Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй гадаад, дотоодын төсөл хөтөлбөрийн болон төрийн бус байгууллагатай хамтарч ажиллах, нутаг дэвсгэрийн хэмжээнд төсөл хэрэгжүүлэх зэргээр иргэдийн нийгмийн асуудлыг шийдвэрлэх арга хэмжээ авна.

6.3. Ижил төстэй уурхай дагаж байгуулагдсан хотуудтай харилцаа тогтоож ёс заншил, түүх, соёл, боловсрол, эдийн засаг, худалдаа, хот тохижилт, бүтээн байгуулалтын чиглэлээр хамтарч ажиллана.

6.4. Аймаг, сум, нийслэл дүүргийн НӨУЁ-ны байгууллагуудтай холбоо тогтоон ажиллаж, орон нутгийн амьдралд нөлөөлөхүйц шинэлэг санаа, ажлын арга барил, хөгжлийн хандлага туршлагыг судалж, сумын онцлогт тохируулан хэрэгжүүлэх арга хэмжээ авна.

6.5. Сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа Төрийн болон Төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, байгууллагуудаас гаргасан нийтлэг ач холбогдол бүхий санал, санаачлагыг дэмжин, сумын ИТХ-ийн дэргэдэх хороодын эрхлэх асуудалтай уялдуулан хамтран ажиллана.

Тайлбар: Сумын ИТХ-ын 2014 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн VIII хуралдаанаар өөрчлөн засварлаж найруулав.

АЖЛЫН ХЭСЭГ



**ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 6 ДАХЬ УДААГИЙН
СОНГУУЛИЙН ЭЭЛЖИТ VIII ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2014 оны 01 сарын 28 өдөр

Дугаар 06

Эрдэнэт

**Чанарын удирдлагын тогтолцооны ISO 9001
олон улсын стандарт нэвтрүүлэх тухай**

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 12 зүйлийн 12.1.3 дахь заалт, Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас 2014 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөг үндэслэн төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилгоор төлөөлөгчөөс гарсан санаачлагыг хурлын хуралдаанаар хэлэлцээд ТОГТООХ нь:

1.Сумын ЗДТГ-т чанарын удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэх ажлын хэсгийн гишүүдийг томилж, Чанарын удирдлагын тогтолцооны олон улсын ISO 9001 стандартыг хэрэгжүүлэх ажлын ерөнхий төлөвлөгөөг батлахыг ИТХ-ын Тэргүүлэгчдэд үүрэг болгосугай.

2.Сумын ЗДТГ-т Чанарын удирдлагын тогтолцооны олон улсын ISO 9001 стандартыг нэвтрүүлж, хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг 2014 онд багтаан зохион байгуулж, шаардагдах зардлыг төсөвт тусгаж ажиллахыг Сумын Засаг дарга /И.Баасанжав/-д, ажлын хэсгийг ахалж ажиллахыг хурлын Тэргүүлэгч /П.Баянмөнх/-д тус тус үүрэг болгосугай.

3.Тогтоолын биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг хурлын дарга /Н.Жаргалсайхан/-д даалгасугай.

ДАРГА

Н.ЖАРГАЛСАЙХАН



**ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 6 ДАХЬ УДААГИЙН
СОНГУУЛИЙН ЭЭЛЖИТ IX ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2014 оны 04 сарын 25 өдөр

Дугаар 02

Эрдэнэт

Малчин багийг Жаргалант суманд
шилжүүлэх тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалт, 4 дүгээр зүйлийн 4.2 дахь заалт, сумын Засаг даргын саналыг хуралдаанаар хэлэлцээд ТОГТООХ нь:

1.Сумын Малчин багийг Жаргалант суманд шилжүүлэх саналыг дэмжиж, Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хуралд хүргүүлсүгэй.

2.Малчин багийг Жаргалант суманд шилжүүлэх санал асуулгын дүн, тооцоо судалгаа, зохион байгуулалтын санал, шаардагдах материалыг Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хуралд хүргүүлэн шийдвэрлүүлэхийг сумын Засаг дарга /И.Баасанжав/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Н.ЖАРГАЛСАЙХАН



**ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 6 ДАХЬ УДААГИЙН
СОНГУУЛИЙН ЭЭЛЖИТ IX ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2014 оны 04 сарын 25 өдөр

Дугаар 03

Эрдэнэт

Сумын Засаг даргын нөөц хөрөнгө зарцуулах,
хяналт тавих журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1, 18 дугаар зүйлийн 18.1.2.в заалт, Төсвийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.18, Сангийн сайдын 2012 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 239 дүгээр тушаалыг үндэслэн Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдаанаар хэлэлцээд ТОГТООХ нь:

1.Сумын Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалтыг оновчтой болгох, төсвийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх зорилгоор Сумын Засаг даргын нөөц хөрөнгийг зарцуулах, хяналт тавих журмыг хавсралтаар баталсугай.

2.Засаг даргын нөөц хөрөнгийг журмын дагуу зарцуулж, гүйцэтгэлийг хагас жилээр Тэргүүлэгчдийн хуралд, бүтэн жилээр хурлын хуралдаанд танилцуулахыг сумын Засаг дарга /И.Баасанжав/-д үүрэг болгосугай.

3.Энэхүү журмыг батлагдсантай холбогдуулан сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны 02 сарын 18-ны өдрийн 30 дугаар тогтоолыг хүчингүй болгосонд тооцсугай.

ДАРГА

Н.ЖАРГАЛСАЙХАН

Баян-Өндөр сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын
2014 оны 04 сарын 25 ны өдрийн 09 дүгээр
хуралдааны 03 дугаар тогтоолын хавсралт

БАЯН-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН НӨӨЦ ХӨРӨНГИЙГ ЗАРЦУУЛАХ, ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Урьдчилан төлөвлөх, нарийвчлан тооцож төсөвт тусгах боломжгүй, тухайн төсвийн жилийн дундуур зайлшгүй санхүүжилт гаргах шаардлагатай зарим зардлыг санхүүжүүлэх болон тухайн шатны Засаг даргад хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой цаг үеийн шинжтэй зарим арга хэмжээг санхүүжүүлэх зориулалт бүхий Засаг даргын нөөц хөрөнгийг зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнахад энэ журмыг мөрдөнө.

Хоёр. Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт

2. Засаг даргын нөөц хөрөнгийг дор дурдсан арга хэмжээг санхүүжүүлэхэд зориулна.
 - 2.1 Хүчтэй цасан болон шороон шуурга, ган, зуд, үер, газар хөдлөлт, цөлжилт, гал түймэр, хүн, мал, амьтны болон ургамлын гоц халдварт өвчин, хортон мэрэгчид тархах зэрэг байгалийн гамшигт үзэгдэл тохиолдсон, нийтийг хамарсан цөмийн болон цацрагийн осол гарсан үед түүний хохирлыг бууруулах, тархалтыг хязгаарлах, үр дагаврыг арилгахад зориулж шатахууны болон бусад зардал.
 - 2.2 Үйлдвэрлэл, технологийн горим зөрчигдсөнөөс барилга байгууламж, шугам, сүлжээ, тоног төхөөрөмж эвдрэх, тээврийн хэрэгсэл сүйрэх, цацраг идэвхт болон химийн хорт бодис алдагдах зэрэг техникийн холбогдолтой томоохон осол гарсан тохиолдолд түүнийг таслан зогсоох, хохирлыг арилгах
 - 2.3 Засаг даргын хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой тухайн төсвийн жилийн дундуур зайлшгүй санхүүжилт гаргах шаардлагатай урьдчилан төлөвлөөгүй, нарийвчлан тооцож төсөвт тусгах боломжгүй, цаг үеийн шинжтэй арга хэмжээг санхүүжүүлэх зардал
 - 2.3.1. Сумын нутаг дэвсгэрт зохион байгуулагдсан тэмдэглэлт үйл явдал, онцгойлох ой, баяр наадмын зардал
 - 2.3.2 Жилийн эцсийн ажлын үр дүнгээр болон олон улсын шинж чанартай тэмцээн уралдаанд тэргүүлсэн аж ахуйн нэгж байгууллага, хувь хүмүүсийг шагнаж урамшуулах зардал
 - 2.3.3. Иргэдээс санал асуулга, судалгаа явуулах зардал
 - 2.3.4. Бусад аймаг, сум, гадаад улс орноос туршлага судлах зардал
 - 2.3.5. Нөөц сангаас урьдчилсан байдлаар гарган орон нутгийн төсвөөс эргэн төвлөрүүлэх хөрөнгө, төсөл арга хэмжээний бусад зардал
 - 2.3.6. Бусад

Гурав. Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалт

- 3.1.Засаг даргын нөөц хөрөнгийг Засаг даргын зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн Засаг даргын захирамжаар зарцуулна.
- 3.2.Засаг даргын нөөц хөрөнгийг зарцуулах шийдвэр нь тухайн жилийн орон нутгийн төсөвт батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн нийт хэмжээнээс хэтрэхгүй байна.
- 3.3.Энэ журмын 2-т заасан арга хэмжээний зардлыг эхний ээлжинд Засаг даргын нөөц сангаас зарцуулаад холбогдох зардлын тайлан, тооцоо тайлбар нэмэлт танилцуулгын хамт ИТХ-ын хуралдаанд хэлэлцүүлэн тухайн жилийн төсөвт тусган батлуулж болох ба энэ тохиолдолд төсвөөс нөөц санд хөрөнгийг буцаан төвлөрүүлнэ.
- 3.4.Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалт, тайлагналтыг Засаг даргын тамгын газрын нягтлан бодогч хариуцан гүйцэтгэнэ.

Дөрөв. Тайлагнал болон хяналт

- 4.1.Нөөц сангийн хөрөнгийн гүйцэтгэлийг Монгол улсын Сангийн сайдын 2012 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 239 тоот тушаалын дагуу тайлагнана.
- 4.2.ЗДТГ-ын нягтлан бодогч Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалт, эх үүсвэрийн үлдэгдлийн талаарх мэдээллийг Засаг даргын зөвлөлийн хуралд улирал бүр танилцуулж байна.
- 4.3.Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалтад сумын ИТХ-ын Төсөв санхүү хөрөнгө оруулалтын хороо хяналт шалгалт хийж, дүнг хуралдаанаар хэлэлцүүлэн үнэлэлт дүгнэлт өгнө.

ООо



**ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 6 ДАХЬ УДААГИЙН
СОНГУУЛИЙН ЭЭЛЖИТ IX ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2014 оны 04 сарын 25 өдөр

Дугаар 04

Эрдэнэт

Журам батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалт, Ариун цэврийн тухай хуулийн 15 дугаар зүйл, 18 дугаар зүйлийн 18.1.4 дэх заалтыг үндэслэн сумын Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар хэлэлцээд ТОГТООХ нь:

1.Сумын нутаг дэвсгэрт нохой, муур тэжээх иргэд, Аж ахуйн нэгжийн дагаж мөрдөх журмыг хавсралтаар баталсугай.

2.Журмыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, тогтоолын биелэлтийг хагас, бүтэн жилээр Хурлын хуралдаанд танилцуулахыг сумын Засаг дарга /И.Баасанжав/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Н.ЖАРГАЛСАЙХАН

Баян-Өндөр сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын
2014 оны 04 дүгээр сарын 25 ний өдрийн ээлжит
09 дүгээр хуралдааны 04 тогтоолын хавсралт

БАЯН-ӨНДӨР СУМЫН ИРГЭД, АЖ АХУЙН НЭГЖ НОХОЙ, МУУР ТЭЖЭЭХ ЭЗЭМШИХ ТАЛААР МӨРДӨХ ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл

Монгол улсын Ариун цэврийн тухай хуулийн 18.1.4 дүгээр зүйлд зааснаар Гэрийн тэжээвэр нохой, муурыг тогтоосон журмын дагуу мал эмнэлгийн үзлэгт оруулж, халдвар хамгааллын дэглэм сахих, хүн мал, амьтны ялгадас, хаягдлаар хот суурины гудамж талбай, зүлэг, ногоон байгууламж, орон сууц, түүний орчныг бохирдуулахгүй байх, мал амьтнаас хүнд халдварладаг өвчин /бруцеллёз, галзуу, сүрьеэ, ям зэрэг/-өөс сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэхэд оршино.

1.1.Энэхүү журмаар иргэд, аж ахуйн нэгж өөрийн өмч хөрөнгийг хамгаалах болон бусад сонирхолын улмаас нохой, муур тэжээж эзэмшсэнээр, нийтийн эрх ашигтай холбогдон үүсэх харилцааг сумын нутаг дэвгэрийн хэмжээнд зохицуулна.

1.2.Харьяалагдах багийн тоо бүртгэлд бүртгүүлж пайз гэрчилгээ авсан, оноосон нэр хочтой, жилийн татвараа хуулийн дагуу төлсөн, мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх үзлэг тарилгад хамрагдсан нохой, муурыг иргэд, ААН-ийн эзэмшлийн гэж үзнэ. Үүнээс бусад нохой муурыг золбин гэж тооцно.

Хоёр. Нохой эзэмшигчийн үүрэг, эрх

2.1.Нохой, муур эзэмшигч иргэн, аж ахуйн нэгж нь нохой, муураа бүртгэл, судалгаанд хамруулж тухай бүр мэргэжлийн байгууллагаас хийх халдварт, паразит өвчнөөс урьдчилан сэргийлэх үзлэг арга хэмжээнд зохих зааврын дагуу хамруулж гэрчилгээнд тэмдэглэл хийлгэсэн байх.

2.2.Нохой, муураа өөрийн эзэмшлийн орон сууц, байр хашаандаа бат бөх уяагаар уяж, нохойтой бол үүдэндээ “Нохойтой” гэсэн анхааруулгыг тавих.

2.3.Нохойгоо өглөөний 06.00 цагаас уяж, оройн 22:00 цагаас хашаандаа сул тавих бөгөөд шөнийн цагаар зөвхөн хашаандаа байлгах. Нохойгоо хашаанаас гадагш гаргахгүй байх.

2.3.Нохой, муур эзэмшсэний татварыг “Татварын тухай” хуулийн 8 дугаар зүйлийн 5.6 дахь заалтыг үндэслэн Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоосон хувь хэмжээний дагуу жил бүрийн 2 дугаар улиралд багтаан төлсөн байх.

2.4.Мал бүхий иргэд нохойгоо мал сүргээс тусгаарлан байнгын уяатай байлгах.

2.5.Нохойгоо салхинд гаргах, олон хүнтэй газар дагуулж явахдаа хамгаалалтын хошуувчтай, бат бөх уяатай байлгах, эзэмшлийн нохой, муур бусдад гэмтэл учруулсан бол яаралтай эмнэлэгт хүргэж тусламж үзүүлэх.

2.6.Нохой, муур эзэмшигч нь хөрш айл болон бусад хүмүүсийн амгалан тайван байдлыг алдагдуулахгүй байх нөхцлийг хангах.

2.7.Нийтийн эзэмшлийн зам талбай, гудамж, ногоон байгууламж, орон сууцны орцыг нохой муурны ялгадас болон бусад зүйлээр бохирдуулахгүй байх.

2.8.Нохой, муурны эрүүл мэнд болон халдварт, паразит өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамруулах талаар мэргэжлийн байгууллага, багийн ажлын албанд хандах.

2.9.Иргэн аж ахуйн нэгж нь хүсвэл эзэмшиж буй нохой муурны нөхөн үржихүйг зогсоолгох талаар харъяа мал эмнэлгүүдэд хандах, өвчилсөн болон эзэмшилгүй /золбин/ нохой, муур /гөлөг, зулзага/-ыг устгуулахаар мэргэжлийн байгууллагад мэдэгдэх.

2.10.Нохой, мууранд ямар нэг өвчний шинж тэмдэг илэрвэл эзэмшигч нь мал эмнэлэг үржлийн нэгжид яаралтай мэдэгдэж, зохих арга хэмжээ авах.

Гурав. Сум, багийн Засаг даргын хүлээх үүрэг

3.1.Золбин гэж тооцогдсон нохой, муурыг устгах ажлыг Хот тохижуулах газар болон бусад ТББ-уудтай хамтран жилийн турш зохион байгуулах.

3.2.Иргэд, ААН-ын эзэмшлийн нохой хүн, малд халдаж гэмтэл учруулсан тухай иргэдээс гарсан санал гомдол батлагдсан тохиолдолд нохойг албадан устгах болон эзэнд нь хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцуулах.

3.3.Гэрийн тэжээвэр нохой, муурыг халдварт паразит өвчнүүдээс урьдчилан сэргийлэх тарилга туулгалтанд хамруулах, гэрчилгээ пайз олгож, бүртгэх ажлыг зохион байгуулах.

3.4.Нохой, муур эзэмшигчдээс төлөх татварыг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар баталсан хувь хэмжээний дагуу орон нутгийн төсөвт төвлөрүүлэх ажлыг зохион байгуулах.

3.5.Орон сууцны орчимд золбин нохой, муур өсч үржихээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг СӨХ-д хэрэгжүүлнэ.

Дөрөв. Хүлээлгэх хариуцлага

Нохой, муур эзэмшихтэй холбогдон гарсан зөрчлийг арилгуулах, хариуцлага тооцох асуудлыг Монгол улсын хууль тогтоомжийн дагуу тусгайлан эрх бүхий албан тушаалтан шийдвэрлэнэ.

4.1.Эзэмшиж буй нохой, муур нь хамгаалалтгүйгээс хүн, малд халдаж гэмтэл учруулсан тохиолдолд гарсан гарз хохирлыг нохой муур эзэмшигч бүрэн хариуцна.

4.2.Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд Захиргааны хариуцлагын тухай хуулийн 32 дугаар зүйлийн дагуу сум, багийн Засаг дарга арга хэмжээ авна.

4.3.Эзэмшиж буй нохой, муур нь эмнэлгийн урьдчилан сэргийлэх тарилга туулгалтанд хамрагдаагүйгээс хүн, мал, амьтанд халдвар тараах, байгаль орчинд хор нөлөө учруулбал Ариун цэврийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь заалтын дагуу иргэд албан тушаалтныг 10.000-50.000, байгууллага аж ахуй нэгжийг 100.000-250.000 төгрөгөөр торгоно.

4.4.Нохой, муур эзэмшигч болон иргэд ААН-ийн хооронд гарсан зөрчил маргааныг цагдаагийн байгууллага болон шүүхээр шийдвэрлүүлнэ.

СУМЫН ЗДТГ



ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 6 ДАХЬ УДААГИЙН
СОНГУУЛИЙН ЭЭЛЖИТ Х ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2014 оны 06 сарын 06 өдөр

Дугаар 02

Эрдэнэт

2014 оны ОНХС-ийн төсвөөс санхүүжүүлэх
хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний
жагсаалтад тодотгол хийх тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2.6 заалт, Төсвийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.4 дэх заалт, 64 дүгээр зүйлийн 64.1.2 заалтыг үндэслэн, Сумын Засаг даргын санал, зураг төсвийг ээлжит Х хуралдаанаар хэлэлцээд ТОГТООХ нь:

1.ОНХС-ийн төсвөөс санхүүжүүлэх 2014 онд батлагдсан хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний жагсаалтын 1.5 дахь заалтад заасан бусад зардлын 1.5.4-т хувиарлагдаагүй үлдсэн **552.139.800** /Таван зуун тавин хоёр сая нэг зуун гучин есөн мянга найман зуун/ төгрөгнөөс ногоон байгууламж нэмэгдүүлэхэд **176.938.846** /Нэг зуун далан зургаан сая есөн зуун гучин найман мянга найман зуун дөчин зургаан/ төгрөг, тохижилтын ажилд **370.721.496** /Гурван зуун далан сая долоон зуун хорин нэгэн мянга дөрвөн зуун ерэн зургаан/ төгрөгийг зарцуулахаар тодотгож жагсаалтыг I хавсралтаар баталсугай.

2.ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжих ажлыг батлагдсан зураг төсвийн дагуу хугацаанд нь гүйцэтгэж, хурлын хуралдаанд танилцуулахыг сумын Засаг дарга /И.Баасанжав/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Н.ЖАРГАЛСАЙХАН



ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 6 ДАХЬ УДААГИЙН
СОНГУУЛИЙН ЭЭЛЖИТ XI ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2014 оны 08 сарын 06 өдөр

Дугаар 02

Эрдэнэт

Тогтоолын хавсралтад нэмэлт
өөрчлөлт оруулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2.б заалт, Төсвийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.2 дахь заалтыг үндэслэн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ээлжит XI хуралдаанаар хэлэлцээд ТОГТООХ нь:

1.2014 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн хуралдааны 03 дугаар тогтоолын I хавсралтын 1.5.7-ийн зураг төсөв бэлэн болоогүйн улмаас зарцуулагдаагүй үлдэгдэл 290.253.188 /Хоёр зуун ерэн сая хоёр зуун тавин гурван мянга нэг зуун наян найман/ төгрөг, 2014 оны ОНХС-ийн хөрөнгө оруулалт хөтөлбөр төсөл арга хэмжээний гүйцэтгэлийн ажлаас хэмнэгдсэн 125.623.352 /Нэг зуун хорин таван сая зургаан зуун хорин гурван мянга гурван зуун тавин хоёр/ төгрөгөөс гүйцэтгэх хөтөлбөр, арга хэмжээний жагсаалт, төсвийн тооцоог хавсралтаар баталсугай.

2.Тогтоолыг хэрэгжүүлж, ОНХС-ийн хөрөнгө нийт 267.131.804 /Хоёр зуун жаран долоон сая нэг зуун гучин нэгэн мянга найман зуун дөрвөн/ төгрөгийг зориулалтын дагуу зарцуулж биелэлтийг хурлын хуралдаанд танилцуулахыг сумын Засаг дарга (И.Баасанжав)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Н.ЖАРГАЛСАЙХАН



**ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 6 ДАХЬ УДААГИЙН
СОНГУУЛИЙН ЭЭЛЖИТ XI ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2014 оны 08 сарын 06 өдөр

Дугаар 03

Эрдэнэт

**Гэр хорооллын хаягжуулалтыг
шинэчлэн тогтоох тухай**

Монгол улсын Хаягжуулалтын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, 4.3 дахь заалт, Засгийн газрын 2013 оны 280 дугаар тогтоолын 5 дугаар зүйлийн 5.1 дэх заалт, Багийн Иргэдийн нийтийн хурлын саналыг Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ээлжит 11 дүгээр хуралдаанаар хэлэлцээд **ТОГТООХ** нь:

1.Сумын нутаг дэвсгэр дэх гудамж, зам талбай, үл хөдлөх хөрөнгийн хаягжилтын зураглалыг I хавсралтаар баталсугай.

2.Харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд хаягжуулах ажлыг зохион байгуулж ажиллахыг багуудын Засаг дарга нарт, тогтоолыг хэрэгжүүлж биелэлтийг хагас жилээрТэргүүлэгчдийн хуралдаанд, бүтэн жилээр хурлын хуралдаанд танилцуулахыг Засаг дарга /И.Баасанжав/-д даалгасугай.

ДАРГА

Н.ЖАРГАЛСАЙХАН



ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 6 ДАХЬ УДААГИЙН
СОНГУУЛИЙН ЭЭЛЖИТ XI ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2014 оны 08 сарын 06 өдөр

Дугаар 04

Эрдэнэт

Багуудын хилийн цэсийг шинэчлэн тогтоох тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3 дахь заалт, 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалт, Хаягжуулалтын тухай хууль, багуудын Иргэдийн нийтийн хурлын саналыг Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ээлжит 11 дүгээр хуралдаанаар хэлэлцээд ТОГТООХ нь:

1.Багуудын хилийн цэсийг шинэчлэн тодотгож өөрчлөлтийн тайлбарыг I хавсралтаар, зургийг II хавсралтаар батлуулах саналыг уламжилсугай.

2.Багуудын хилийн цэсийг шинэчлэн тогтоох санал, зургийг Аймгийн ИТХ-ын хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулахыг сумын Засаг дарга /И.Баасанжав/-д үүрэг болгосугай.

3.Энэ тогтоол гарсантай холбогдуулан сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2009 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн хуралдааны 05 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

Н.ЖАРГАЛСАЙХАН

Сумын ИТХ-ын 2014 оны 08 дугаар сарын 06-ны
өдрийн ээлжит 11 дугаар хуралдааны 01 дугаар
тогтоолын хавсралт

БАЯН-ӨНДӨР СУМЫН БАГУУДЫН НУТАГ ДЭВСГЭРИЙН ХИЛИЙН ЗААГ ШИНЭЧЛЭН ТОГТООХ ТУХАЙ

1.3эст

Холбооны 4 замын уулзвараас эхлэн Д.Нацагдоржийн гудамжаар өгсөн,эмнэлгийн замаар, үерийн усны хамгаалалтын шуудуу хүртэл 557 м, Баян-өндөр уулын холбооны релейний өндөр хүчдэлийн шугамаар 892 м, зүүн хойш 1428,3тоот өндөрлөгөөс зүүн урагш 1510,1 тоот өндөрлөг,пирамидын 1424,816 тоот өндөрлөг, хүнсний үйлдвэрийн баруун хойд замын уулзвар, замаа дагаж Эрээний гудамж, төв замыг даган, барилгачдын талбайн уулзвар, холбооны 4 замын уулзвар хүртэл

Нийт нутаг дэвсгэрийн хэмжээ:225,41га (хавсралт зураг 1)

2.0юут

“Мэдээлэл хобоо сүлжээний”ТӨХКбаруун урд зүгт байрлах4 замын уулзвараас зүүн тийш Сүхбаатарын өргөн чөлөөгөөр 1500 м, Барилгачдын талбайн уулзвараас Эрээний гудамжийг даган, Эрдэнэт хивс ХХК-ны урд талын 3-н замын уулзвар, уулзвараас чанх урагш 1368,0 тоот өндөрлөг, баруун тийш 1417,8 тоот өндөрлөг, полигнометрын 15 дугаартай1332.642 тоот,Шунхлай ШТС-ын зүүн урд талын уулзвар хүрч, А.Ф.Трюковын нэрэмжит гудамжаар өгсөж, холбооны 4 замын уулзвар хүртэл

Нийт нутаг дэвсгэрийн хэмжээ:359,11га (хавсралт зураг 1)

3.Уурхайчин

Аймгийн ЗДТГ-ын баруун 4 замын уулзвараас Д.Сүхбаатарын өргөн чөлөөгөөр “Мэдээлэл холбоо сүлжээний”ТӨХК зүүн 4 замын уулзвар, А.Ф.Трюковын нэрэмжит гудамжаар уруудан, "Шунхлай" ШТС-ын зүүн урд талын уулзвар, полигнометрын 15 дугаартай 1332.642 тоот, баруун урагшаа 1417,8 тоот өндөрлөг, Оюутны гудамж, тус гудамж дулааны шугамаа даган зүүн тийшКувейтын гудамжны аюулгүйн тойрог, Кувейтын гудамжаар өгсөж, Д.Сүхбаатарын өргөн чөлөөний уулзвар хүртэл.

Нийт нутаг дэвсгэрийн хэмжээ:182,27га (хавсралт зураг 1)

4.Хүрэнбулаг

“Мэдээлэл холбоо сүлжээний”ТӨХК зүүн 4 замын уулзвараасД.Сүхбаатарын өргөн чөлөөгөөр баруун тийш 800 м, Орхоны гудамжаар хойш эргэн Улаан-Үдийн гудамж, баруун тийш эргээд ОХУ-ын консулын зүүн талын зам, дээш өгсөж, 13-р сургуулийн баруун талын хашаа, түүнээс баруун тийш гараж хүртэл, дээш өгсөн Албан бус боловсрол төвийн хашааны зүүн талаар үерийн усны хамгаалалтын шуудуу, шуудуугаа дагаж зүүн тийш Хүрэнбулаг рашааны жалга, баруун хойш жалга өгсөөд Баян-Өндөр уулын релей уруу явсан өндөр хүчдэлийн шугам, шугаглаа дагаад жалгын үерийн усны хамгаалалтын шуудуу, эмнэлгийн баруун тал Д.Нацагдоржийн гудамжаар доош уруудаж, холбооны 4-н замын уулзвар хүртэл.

Нийт нутаг дэвсгэрийн хэмжээ:136,803га (хавсралт зураг 1)

5.Уртбулаг

Найрамдлын талбайн зүүн талын уулзвараас Д.Сүхбаатарын өргөн чөлөөгөөр баруун тийш, "Эрдэнэт хивс"ХХК-ний Номин худалдааны төвийн зүүн талын замаар Орхон цогцолбор сургуулийн хашаа хүртэл, Биеийн тамир спорт хорооны урдуур явган хүний замаар өгсөн, 1-р

цэцэрлэгийн урдуур гарч, баруун хойш эргэн, Баян-Өндөрийн нэрэмжит гудамжийг даган, баруун хойш эргэн 5-р хорооллын 18-р байрны ард талынгражуудын зүүн талаар үерийн хамгаалалтын шуудуу хүрэн, зүүн хойш шуудуугаа дагаад 50 м яваад чанх урагш Албан бус боловсрол төвийн хашааны зүүн талаар граж хүртэл, гражаас зүүн тийш эргэн 13-р сургуулийн баруун талын төмөр хашаа, ОХУ-ын консулын зүүн талын замаар Улаан-Үдийн гудамж, зүүн тийш Х.Магсаржавын гудамжны уулзвар, Орхоны гудамжаар уруудан Найрамдлын талбайн зүүн талын уулзвар хүртэл.

Нийт нутаг дэвсгэрийн хэмжээ: 40,22 га (хавсралт зураг 1)

6.Бүрэнбүст

"Эрдэнэт хивс"ХХК-ний Номин худалдааны төвийн зүүн талын замын уулзвараас Д.Сүхбаатарын өргөн чөлөөгөөр Баян-Өндөрийн нэрэмжит гудамжны уулзвар, хойш уг гудамжийг даган Баянбулаг баг уруу явдаг замын уулзвар, жалгаар дээш өгсөж, үерийн усны хамгаалалтын шуудуу хүртэл, зүүн тийш шуудуугаа даган 220 м, чанх урагш 5-р хорооллын 18-р байрны ард талын гражийн баруун талаар Баян-Өндөрийн нэрэмжит гудамж хүртэл 365 м, баруун тийш 60 м яваад, урагшаа 15-р цэцэрлэгийн баруун талын явган хүний замаар уруудаж, зүүн тийш 1-р цэцэрлэгийн ард талаар 155 м, урагш явган хүний замаар уруудан, Биеийн тамир спорт хорооны урдуур гарч, "Орхон цоцолбор" сургуулиас замаа даган урагшаа "Эрдэнэт хивс" ХХК-ны Номин худалдааны төвийн зүүн талын уулзвар хүртэл.

Нийт нутаг дэвсгэрийн хэмжээ: 22,03 га(хавсралт зураг 1)

7.Согоот

Найрамдлын талбайн баруун талын 4-н замын уулзвараас чанх урагш Кувейтын гудамжаар Аюулгүйн тойрог, баруун тийш Эрдэнэт-Булганы чиглэлийн А1002 асфальтон төв замыг дагаж 520 м яваад дээш эргэн, Баян-Өндөрийн нэрэмжит гудамжийг өгсөн, Д.Сүхбаатарын өргөн чөлөөний 4 замын уулзвар, зүүн тийш Д.Сүхбаатарын өргөн чөлөөгөөр Найрамдлын талбайн баруун талын 4-н замын уулзвар хүртэл.

Нийт нутаг дэвсгэрийн хэмжээ: 21,88 га(хавсралт зураг 1)

8. Булаг

Өрхийн эмнэлгээс баруун тийш дулааны шугамаа дагаж, Булаг багийн 19-р гудамжны баруун талаар дээш эргэн, замаа даган Булаг багийн 32-р гудамжны баруун талын Цагаан худаг хүрээд, дээш 420 м яван, зүүн тийш жалга уруу 50 м явж, жалгаар дээш өгсөн 950 м, Баян-Өндөр уулын хамгаалалтын торон хашаа, хашааг даган зүүн тийш жалга хүртэл 850 м, жалга дагаж 625 м уруудан, баруун тийш эргэн 175 м явж, Булагийн 146-6 тоот хашааны зүүн хойд өнцөг хүрч, 14-р гудамжны зүүн талаар уруудан, 10-р гудамжны зүүн талын худаг, сайжруулсан шороон замаа дагаж Өрхийн эмнэлэг хүрнэ.

Нийт нутаг дэвсгэрийн хэмжээ: 138,48 га(хавсралт зураг 2)

9.Баянбулаг

Булаг багийн өрхийн эмнэлэгийн урдуур явсан дулааны шугамаас хойш сайжруулсан шороон замаар дээш өгсөж, Булагийн 10-р гудамжны зүүн талын худаг хүрч, 14-р гудамжны зүүн талаар дээш 800 м, Булагийн 146-6 тоот хашааны зүүн хойд өнцөг хүрч, баруун тийш эргэн жалга хүртэл 175 м, жалгаараа дээш 625 м, Баян-Өндөр уулын хамгаалалтын торон хашаа, хашаагаа дагаж зүүн тийш 745 м, чанх урагш жалга хүртэл 154 м, жалгаа даган 760 м явж, Хүрэнбулагийн рашааны жалганы уулзвар, урагш уруудан 11-р хорооллын үерийн хамгаалалтын шуудуу хүртэл 165 м, баруун тийш үерийн хамгаалалтын шуудууг даган Баянбулаг багийн 3-р хэсгийн зүүн талын жалга, жалгаа уруудан 400 м, 5-р хорооллын 15-р

байрны араар Баянбулаг баг уруу явдаг замын уулзвараас дулааны шугам хүртэл 800 м, гэр хороолол уруу явсан дулааны шугамаа дагаж 630 м явж, өрхийн эмнэлэг хүрнэ.

Нийт нутаг дэвсгэрийн хэмжээ: 149,189 га(хавсралт зураг 3)

10. Цагаанчулуут

Гэр хорооллын эцсийн буудлаас зүүн тийш дулааны шугамаа даган 5-р хорооллын Баян-Өндөрийн **нэрэмжит** гудамж, гудамжаа даган уруудаж Эрдэнэт-Булганы чиглэлийн А1002 асфальтон төв зам, баруун тийш **төв замаа** даган "Жаст-Ойл"ХХК-ны ШТС, замаа даган дээш өгсөж, гэр хорооллын эцсийн буудал хүрнэ.

Нийт нутаг дэвсгэрийн хэмжээ: 171,72 га(хавсралт зураг 4)

11 .Рашаант

Шанд багийн 1-р гудамжны баруун өнцөгөөс зүүн тийш 400 м-т жалга хүрээд, жалгаауруудан 280 м, Наран багийн 44-р гудамжны баруун урд өнцөгөөс гэр хорооллын асфальтон зам 180 м хүрч, замаа дагаж 565 м уруудаж гэр хорооллын эцсийн буудал, эцсийн буудлаас замаа дагаж уруудан "Жаст-Ойл"ШТС-руу 560 м, баруун тийш Шанд, Их залуу багийн асфальтан замын уулзвар 735м, Уулвараас асфальтан замаа даган 1050 м, Шанд багийн 33-р гудамжны зүүн урд өнцөг, дээш жалгаа дагаж 480 м, Шанд багийн 1-р гудамжны баруун урд өнцөг хүрнэ.

Нийт нутаг дэвсгэрийн хэмжээ: 108.38 га(хавсралт зураг 5)

12. Уртын гол

Гэр хорооллын эцсийн буудлаас асфальтон замаа дагаж уруудан 827м, "Жаст-Ойл"ШТС ийн баруун талаар Эрдэнэт Булганы чиглэлийн А1002 асфальтон замыг хөндлөн гараад Сод монгол ШТС ийн баруун тал, урагшаа Уртбулагийн голын гольдрол хүрч 435 м, Уртбулагийн голын гольдролоор дээш өгсөж 560 м, Дэнж, Эрдэнэ багийн хилийн уулзвараар баруун тийш 265 м уул өөд өгсөж, геодезийн полигнометрийн 1231 дугаартай цэг(1383.54) тоот , баруун тийш замын карьерийн дундуур, шинэ худагийн урдуур 1050 м, баруун хойш ЭрдэнэтЭрдэнэт Булганы чиглэлийн А1002 асфальтон зам хүртэл 550 м, Эрдэнэт Булганы чиглэлийн А1002 асфальтон замыг даган зүүн тийш 710 м, Уртбулагийн голын гольдролоор дээш шуудуу даган 780 м, шинээр тавьсан хөндлөн авто зам хүрч зүүн тийш 370 м явж 3 замын уулзвар хүрнэ.

Нийт нутаг дэвсгэрийн хэмжээ: 163.51 га(хавсралт зураг 6)

13.Наран

Гэр хорооллын эцсийн буудлын баруун талын асфальтон замаар 450 м өгсөж, Нарангийн 44-р гудамжны зүүн урд өнцөг, баруун тийш эргэж, гудамжны баруун урд өнцөг, жалга даган өгсөж, шинэ тавьсан асфальтон зам, замаас дээш Шанд, Наран багийн заагаар өгсөж, Нарангийн 71-р гудамжны урдуур баруун тийш эргэж, Шандын 59-р гудамжны зүүн үзүүрээр жалгаа даган 790 м өгсөж,Баян-Өндөр уулын хамгаалалтын торон хашаа, хашаагаа даган зүүн тийш 350 м, урагш жалгаа даган 950 м уруудаж, баруун тийш 50 м, урагш уруудан гэр хорооллын асфальтан зам хүртэл 340 м, замаа дагаж Цагаанчулуут багийн ард талын дулааны шугам, дулааны шугамаа даган баруун тийш гэр хорооллын эцсийн буудал хүрнэ.

Нийт нутаг дэвсгэрийн хэмжээ: 124.01 га(хавсралт зураг 7)

14. Шанд

Овоо толгойгоос аймгийн хилээ дагаад 573 м, Бугат сумын модны захын хашааны зүүн булангийн урд 1395.50 тоот, зүүн тийш асфальтон замаа дагаж 17-р сургуулийн баруун талын замын уулзвар 1150 м, зүүн тийш гэр хорооллын асфальтон замаа дагаж 837 м, замаас урагш жалга даган 140 м, Шандын 1-р гудамжны урдуур баруун тийш 550 м, урагшаа жалгаа даган,

Шанд багийн асфальтон зам хүртэл 480 м, замаа даган 120 м, баруун тийш Шандын 31-р гудамжаар баруун тийш 520 м, Уртбулагийн голын гольдролоор дээш 130 м өгсөж, баруун тийш Шандын баруун задгайн 20-р гудамжны урдуур 1080 м, Овоо толгойд хүрнэ.

Нийт нутаг дэвсгэрийн хэмжээ :94,33 га(хавсралт зураг 9)

15.Даваат

Бугат сумын модны захын хашааны зүүн булангийн урд 1395.50 тоот,аймгийн хилээ дагаад Уртбулагийн амын доод үзүүр хүртэл 1910 м, зүүн тийш Шанд 61-р гудамжны зүүн талын жалга хүртэл 1000 м, жалгаа уруудаж 380 м, зүүн тийш эргэж, шинэ худгийн чиглэлд 153 м, худагаас зүүн тийш 290 м, Наран багийн 70-р гудамжаар уруудан Наран, Шанд багийн гудамжны заагаар гэр хорооллын асфалтан зам хүртэл 850 м, баруун тийшасфалтан замаадаган 837 м,замын уулзавараас баруун тийш 17-р сургуулийн урдуур замаа дагаж1150 м хүрнэ.

Нийт нутаг дэвсгэрийн хэмжээ :215,50 га(хавсралт зураг 10)

16.Эрдэнэ

Бүрэнбүстийн овооноос хойш 2150 м өгсөж,1363.2 тоот өндөрлөг, баруун хойд зүгт аймгийн хил дагаж 1100 м, Эрдэнэт-Булганы асфалтан төв замыг дагаж 980 м, зүүн урагшаа550м, зүүн тийш шинэ худагийн урдуур,замын карьерийн дундуур 1050 м геодезийн полигнометрийн 1231 дугаартай цэг, зүүн тийш Уртын гол багийн хилийн уулзвараар зүүн тийш 265 м уулаа уруудаж зүүн урагш Дэлийн хошуу дээрх полигнометрийн 1865 тоот цэг хүртэл 800м, урагш баруун дэнжийн 21-р гудамжны баруун талын нарийн чөлөөгөөр уруудаж төв зам хүрч, жалгаа даган урагшаа Сархиа уул хүртэл 1182 м, зүүн урагш уулын жалга дагаж Чингэлийн гол, голоо өгсөн Бүрэнбүстийн овоо хүртэл.

Нийт нутаг дэвсгэрийн хэмжээ:1151.08га(хавсралт зураг 12)

17. Дэнж

Кувейтын гудамж буюу аюулгүй тойрогоор баруун урагш эргэж, дулааны шугамаа даган 602 м, урагшаа 1417.8 тоот өндөрлөг хүртэл 1623 м яваад, баруун тийш Сархиа уул хүртэл 1011 м, чанх хойшоо эргэж, баруун Дэнжийн 30-р гудамжны баруун талын чөлөөгөөр хойшоо чигээрээ яван төв зам гарч, баруун дэнжийн 21-р гудамжны баруун талын нарийн чөлөөгөөр чигээрээ 613 м, геодезийн хэмжилтийн 1865 дугаарын хатуу цэг, энгэр хүртэл 815 м,зүүн тийш Уртбулагийн голын гольдролоор 230 м, хойшоо эргэж “Жаст-Ойл”ХХК-ны ШТС хүртэл 375 м, Эрдэнэт-Булганы чиглэлийн А1002 асфальтонзамаа даган зүүн тийшКувейтын гудамж буюу аюулгүйн тойрог хүртэл 2373 м.

Нийт нутаг дэвсгэрийн хэмжээ: 473,52 га(хавсралт зураг 13)

18.Их залуу

Их залуу багаас хойш шинээр тавьсан асфальтон замаас зүүн тийш Их залуу багийн Баруун задгай 19-р гудамжны араар 1080 м, зүүн үзүүрт нь хүрээд урагш 130 м, Шандын 30-р гудамжны араар 520 м, асфальтонзамаа дагаж 1138 м, геодезийн хэмжилтийн полигнометрийн 1253 цэг хүрч, баруун тийш эргэж полигнометрийн 0111 цэг, урагш эргэж, шуудуугаа даган Эрдэнэт-Булганы төв зам, баруун тийш замаа даган 480 м, Их залуу багийн замын уулзвараас хойш замаа дагаж 2780 м хүрнэ.

Нийт нутаг дэвсгэрийн хэмжээ: 170,075 га(хавсралт зураг 14)

19. Яргуйт

Бурагийн хөтөлөөс баруун хойш аймгийн хилийн цэс дагаж, Овоот толгойн 1469,8 тоот өндөрлөг хүрч, зүүн тийш 590 м уруудажшинээр тавьсан асфальтон зам хүрээд замаа дагаж Эрдэнэт-Булганы чиглэлийн А1002 асфальтон төв зам, төв замаа дагаж аймгийн хилийн цэс хүрнэ.

Нийт нутаг дэвсгэрийн хэмжээ: 739,94 га(хавсралт зураг 15)

20.Баянцагаан

Хадтай толгойгоос зүүн тийш Тахилт овоо хүртэл 3308 м, урагш эргэж төмөр замын фрезер, зүүн тийш Эрдэнэт голоо даган уруудаж 3-н замын уулзвар, баруун тийш эргэж, Алтан тэвш толгой хүртэл 7125 м, 1418.6 тоот өндөрлөг хүртэл 3252м, тбаруун хойшоо эргэж 1375.1 тоот өндөрлөг" эгц хойш чигээрээ явж 1368.0 тоот өндөрлөгийг дайрч төв зам гаран, "Эрдэнэт хивс" ХХК-ны урдуур төв зам дагаж өгсөн, Хүнсний үйлдвэрийн баруун үзүүрт хүрч, хойшоо усан сан, баруун хойшоо чигээрээ Хадтай толгой хүрнэ. **Нийт нутаг дэвсгэрийн хэмжээ:5404,216 га**(хавсралт зураг 16)

21.Говил

1484.0 тоот өндөрлөгөөс баруун тийш 1376.1 тоот өндөрлөг, урагш эргээд Дунд хөтөл /1311.6/, Доод хөтөл /1318.0/, 1358.5 тоот өндөрлөг, урагш хэмжилтийн пирамид, чанх урагш Эрдэнэт гол, голоо дагаж өгсөн төмөр замын фрезер хүрч, хойшоо эргэн Тахилт овоо хүртэл, түүнээс баруун хойш 2954 м, Ар булагийн модон дундуур 1365 м явж, ар булагийн айлуудын урдуур 1484.0 тоот өндөрлөг хүрнэ.

Нийт нутаг дэвсгэрийн хэмжээ: 1919,036 га(хавсралт зураг 18)

22. Малчин баг

1496.0 тоот өндөрлөгөөс Ингэтийн даваа, Бөхөнгийн өвөр Их залаат уул, урагш Хутаг-Өндөр уул, чигээрээ баруун урагш Согоот уулын оройгоор Алтан тэвш толгой, хойш эргээд Эрдэнэт-Хялганатын 3 замын уулзвар, Эрдэнэт голоо дагаад хэмжилтийн пирамид, хойшоо эргээд Доод хөтөл, Дунд хөтөл, 1376 тоот өндөрлөг, урагш эргээд Ар булагийн дээд эхээр орж зүүн урагш Тахилт толгой, Баян-Өндөр уулын хамгаалалтын торон хашааг дагаж, 1496.0 тоот өндөрлөг хүрнэ.

Нутаг дэвсгэрийн хэмжээ: 14097,0125 га

1417.0 тоот өндөрлөгөөс 1368 тоот өндөрлөг, зүүн урагш эргэж 1875 тоот өндөрлөг, хиймэл уулын урдуур зүүн тийш 1418.6 тоот өндөрлөг, урагш Хөөвөрийн баруун талын толгой, Чингэлийн голоо дагаж 5517м өгсөөд хойш эргэж 1336.8, 1426.2 тоот өндөрлөгүүдийг дайрч Сархиа уул, дээш өгсөж 1417.8 тоот өндөрлөг хүрнэ.

Нутаг дэвсгэрийн хэмжээ 1645,232 га

Малчин багийн нийт нутаг дэвсгэрийн хэмжээ **15742,244 га**



**ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 6 ДАХЬ УДААГИЙН
СОНГУУЛИЙН ЭЭЛЖИТ XII ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2014 оны 10 сарын 24 өдөр

Дугаар 02

Эрдэнэт

**Төлөөлөгчийн бүрэн эрхийг
зөвшөөрөх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1-ийн “а” заалт, Аймаг сум дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.8 дахь заалт, Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 11 дүгээр тойргийн нөхөн сонгуулийн дүнгийн тухай сумын сонгуулийн хорооны дарга Х.Машбатын илтгэлийг хэлэлцээд ээлжит XII хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 11 дүгээр тойргийн нөхөн сонгуулийн дахин санал хураалтын дүнгээр хамгийн олон сонгогчийн санал авч сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын төлөөлөгчөөр сонгогдсон Бямбадоржийн Цэвэгмидийг Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгчөөр тооцож, бүрэн эрхийг зөвшөөрч баталсугай.

2. Төлөөлөгч Б.Цэвэгмидэд сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгчийн үнэмлэх, энгэрийн тэмдэг олгосугай.

ДАРГА

Н.ЖАРГАЛСАЙХАН



**ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 6 ДАХЬ УДААГИЙН
СОНГУУЛИЙН ЭЭЛЖИТ XII ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2014 оны 10 сарын 24 өдөр

Дугаар 03

Эрдэнэт

Сумын нутаг дэвсгэрт 2015 онд ОНХС-гийн
хөрөнгөөр хэрэгжүүлэх хөтөлбөр төсөл арга хэмжээг
эрэмбэлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25.1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63, 3 дахь заалт, багийн Иргэдийн нийтийн хурал дээр гаргасан саналыг тэргүүлэх ач холбогдлоор нь төсөл арга хэмжээг эрэмбэлсэн тухай сумын Засаг даргын илтгэлийг сонсоод Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ээлжит XII хуралдаанаас ТОГТООХ нь:

1.2015 онд ОНХС-гийн хөрөнгөөр хийгдэх ажлын эрэмбэ дарааллыг хавсралтаар баталсугай.

2.Эрэмбэлсэн саналын дагуу 2015 оны төсвийн төслийг боловсруулахад Сумын Иргэдийн хурлын Төлөөлөгчдийн саналыг тусган, ОНХС-гийн төсөв батлуулахыг Засаг дарга /И.Баасанжав/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Н.ЖАРГАЛСАЙХАН

Сумын ИТХ-ын 2014 оны 10 дугаар сарын 24-ны
өдрийн ээлжит 12 дугаар хуралдааны 01 дугаар
тогтоолын хавсралт

Эрэмбэ	Хэлэлцэгдсэн санал	Авсан саналын тоо	Дүнд эзлэх хувь
Үндсэн саналуудаас Баян-Өндөр сумын "Орон нутгийн хөгжлийн сан"-ийн хөрөнгөөр хийгдэх боломжтой ажлуудын эрэмбэ			
1	Хүүхдийн тоглоомын талбайг нэмэгдүүлэх	6059	58.6%
2	Сургууль, цэцэрлэг, эмнэлгийн сургалтын орчинг сайжруулах	6040	58.4%
3	Хогийн савыг нэмэгдүүлэх	5092	49.2%
4	Явган хүний зам талбайг засах	4791	46.3%
5	Гудамж талбай, байр хоорондын гэрэлтүүлгийг нэмэгдүүлэх	4790	46.3%
6	Ажлын байр нэмэгдүүлэх/бүлэг байгуулах, түр болон байнгын ажлын байр г.м/	4760	46.0%
7	Нэг цэгийн үйлчилгээтэй болох	4744	45.9%
8	Жижиг дунд үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зээлийг хүртээмжтэй болгох	4370	42.3%
9	Хороололд иргэдийн оролцоотой халуун усыг нэмэгдүүлэх	4349	42.1%
10	Wi-Fi талбай байгуулах	4315	41.7%
11	Ус зайлуулах далан, суваг	4040	39.1%
12	Иргэдийн оролцоотой ногоон байгууламжийг нэмэгдүүлэх	3813	36.9%
13	Нийтийн бие засах газрыг нэмэгдүүлэх	3647	35.3%
14	Байрны гадны фасад, гудамжны өнгө үзэмжийг сайжруулах	3240	31.3%
15	Иргэдэд үйлчлэх төрийн үйлчилгээний орчин нөхцөлийг сайжруулах	3095	29.9%
16	Явган хүний гүүр барих	2877	27.8%
17	Багуудын иргэний танхимыг тохижуулах, тоног төхөөрөмжийг нэмэгдүүлэх	2625	25.4%
18	Дээврийн засвар үйлчилгээ хийх	2602	25.2%
19	Байрнуудын хаалгыг код бүхий цоожтой болгох	2495	24.1%
20	Байрнуудын сантехникийн засвар хийх	2491	24.1%
21	Соёлын төвийн засвар үйлчилгээ, тоног төхөөрөмжийг нэмэгдүүлэх	1918	18.5%
22	Заадасны засвар үйлчилгээ хийх	1647	15.9%
23	Хаяавчны засвар үйлчилгээ хийх	1282	12.4%
24	Малын үүлдэр угсааг сайжруулах	1256	12.1%
25	Хадлангийн талбайг хашиж хамгаалах, өвс тэжээлийн саравч барих	1009	9.8%
Нэмэлтээр өгсөн саналуудаас Баян-Өндөр сумын "Орон нутгийн хөгжлийн сан"-ийн хөрөнгөөр хийгдэх боломжтой ажлууд			
1	Авто зам засах	187	1.8%
2	Худаг нэмж барих	174	1.7%
3	Дулааны шугаманд холбох	165	1.6%

4	Хогны машинтай болох	125	1.2%
5	Багийн нутаг дэвсгэрийг камержуулах	93	0.9%
6	Гудамжинд хайрга асгаж, тэгшлэх	88	0.8%
7	Машин, явган хүний гүүр нэмж барих	76	0.7%
8	Утаагүй зуух хөтөлбөрийг хэрэгжүүлэх	54	0.5%
9	Нохой муур устгах	50	0.5%
10	Яргуйт багийн хабитат, Хөтөлийн алслагдсан 2.2 км газар богино рейсээр микро автобус явуулах	49	0.5%
11	Яргуйт багт засмал зам тавих, үерийн далан шуудуу бариулах	49	0.5%
12	Яргуйт багт гудамжны гэрэлтүүлэг, гэрлийн хүчдэлийг нэмэгдүүлэх	49	0.5%
13	Дулаан дамжуулах төв барих	47	0.5%
14	Гудамжны өнгө үзэмж сайжруулах	43	0.4%
15	6-14 хажууд ухсан нүхийг бөглөх, явган хүний замыг шийдвэрлэх	41	0.4%
16	6-22 болон 6-11 хооронд хурд сааруулагч тавих	41	0.4%
17	Олон нийтийн оролцоотой тохижилтын ажил хийх	41	0.4%
18	Өндөр настнууд уулздаг газартай болох	41	0.4%
19	24 цагийн эмийн сантай болох	41	0.4%
20	14-р сургуулийн өргөтгөл	40	0.4%
21	Зэрлэг ургамлын хор цацах	40	0.4%
22	Бохирын нэгдсэн шугам татах	40	0.4%
23	Цэвэр бохир усны шугам татах	37	0.4%
24	Явган хүний замд хашлага хийх	34	0.3%
25	Цахилгааны хүчдэл нэмэгдүүлэх	31	0.3%
26	Нийтийн тээврийн зогсоолыг нэмэгдүүлж, автобусны үйлчилгээг сайжруулах	31	0.3%
27	Ширээний теннисний орчин үеийн шаардлага хангасан заал, танхимтай болох	21	0.2%
28	Хүнсний бөөний төвтэй болох	18	0.2%
29	Гэрэлтүүлэг нэмэгдүүлэх	3	0.03%
Нэмэлтээр өгсөн саналуудаас Орхон аймгийн "Орон нутгийн хөгжлийн сан"-ийн хөрөнгөөр хийгдэх боломжтой ажлууд			
1	Цэцэрлэг барих	150	1.4%
2	Багт эмнэлэг байгуулах	33	0.3%
3	Аймгийн хэмжээнд нэгдсэн эмнэлэгтэй болох	1	0.01%
Хөрөнгө шаардагдахгүй саналууд			
1	Микро автобус явуулж байх /Маршрут сунгах/	74	0.7%
2	Худгуудыг ажилд оруулах	54	0.5%
3	Цагдаагийн хэсэгтэй болох	54	0.5%
4	Саналын хайрцагтай болох	41	0.4%
5	СӨХ-ийн үйл ажиллагааг сайжруулах	40	0.4%
6	Хогийг график, хугацаанд ачих	37	0.4%
7	Хөдөлгөөнт эргүүл тогтмол ажиллуулах	33	0.3%
8	Хогны машинуудыг тогтмол ажиллуулдаг байх	1	0.01%
9	Хогоо цаг тухайд нь ачих	1	0.01%



**ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 6 ДАХЬ УДААГИЙН
СОНГУУЛИЙН ЭЭЛЖИТ XII ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2014 оны 10 сарын 24 өдөр

Дугаар 04

Эрдэнэт

**Ойн нөхөрлөлүүдийн мэдээлэл
сонссон тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 дахь заалт, Ойн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, 18.2.1 дэх заалтуудыг үндэслэн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ээлжит XII хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Сумын нутаг дэвсгэрт ойн санг гэрээгээр эзэмшиж байгаа нөхөрлөлүүдийн гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлтийг дүгнэж, ойн нөхөрлөл, ААН-үүдийн цаашдын үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн, хуралдаанд танилцуулахыг Засаг дарга /И.Баасанжав/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Н.ЖАРГАЛСАЙХАН



**ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 6 ДАХЬ УДААГИЙН
СОНГУУЛИЙН ЭЭЛЖИТ XIII ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2014 оны 12 сарын 12 өдөр

Дугаар 02

Эрдэнэт

2014 оны үндсэн чиглэлийн
биелэлтийн тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1.д дэх заалт, Сумын эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийн тухай сумын Засаг даргын илтгэлийг хэлэлцээд **ТОГТООХ нь:**

1.Сумын эдийн засаг нийгмийг 2014 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийг төлөөлөгчдийн олонхийн саналаар **ХАНГАЛТТАЙ** гэж дүгнэсүгэй.

ДАРГА

Н.ЖАРГАЛСАЙХАН



**ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 6 ДАХЬ УДААГИЙН
СОНГУУЛИЙН ЭЭЛЖИТ XIII ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2014 оны 12 сарын 12 өдөр

Дугаар 03

Эрдэнэт

Сумын эдийн засаг нийгмийг 2015 онд
хөгжүүлэх үндсэн чиглэлийг батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1.д дэх заалт, Сумын эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төслийг хуралдаанаар хэлэлцээд ТОГТООХ нь:

1.Сумын эдийн засаг нийгмийг 2015 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг I хавсралтаар баталсугай.

2. Сумын эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө зардлын эх үүсвэрийг оновчтой тооцож ОНХС-гийн төсвийг батлуулсугай.

3. Хурлын хуралдаанд төлөөлөгчдөөс гарсан саналыг үндсэн чиглэлд тусган, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтийг хагас жилээр Тэргүүлэгчдийн хуралдаанд, бүтэн жилээр хурлын хуралдаанд танилцуулахыг сумын Засаг дарга /И.Баасанжав/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Н.ЖАРГАЛСАЙХАН

Орхон аймгийн Баян-Өндөр сумын Иргэдийн төлөөлөгчдийн
хурлын 2014 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн ээлжит
13 дугаар хуралдааны 01 тогтоолын хавсралт

БАЯН-ӨНДӨР СУМЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2015 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ

10	Зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хариуцах албан тушаалтан	Зардал: Эх үүсвэр
НЭГ. ЭРХ ЧӨЛӨӨТЭЙ ИРГЭДТЭЙ ИРГЭНШСЭН ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМ					
1.Нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааг шинэчлэх чиглэлээр:					
1.	1.1.1.Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хуульд заасан эрхийн дагуу аж амьдралын аливаа асуудлыг Ардчилсан нээлттэй байдлаар иргэд өөрсдөө шийдвэрлэж байхын тулд сумын дүрмийг нийтийн саналыг тусган боловсруулж батлан мөрдөнө.	1.1.1.1.Засгийн газрын болон аймгийн бодлогын баримт бичгүүдтэй уялдуулан сумын хөгжлийн хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх.	Жилдээ	Засаг дарга ЗДТГ-ын дарга	Хөрөнгө шаардахгүй
2.	1.1.2. Иргэний танхим байгуулан суманд тулгамдаж буй асуудлаар иргэдийн дунд санал асуулга явуулж хэлэлцүүлэн тэдний саналд үндэслэн шийдвэр гаргадаг болно.	1.1.2.1. ЗДТГ, баг бүрт иргэний танхим байгуулан шаардагдах техник хэрэгсэл, эд хогшлоор ханган иргэд санал хүсэлтээ илэрхийлэх, мэдээлэл авах, нөхцөл бүрдүүлэх.	Жилдээ	Засаг дарга БХМ	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр
3.	1.1.2. Иргэний танхим байгуулан суманд тулгамдаж буй асуудлаар иргэдийн дунд санал асуулга явуулж хэлэлцүүлэн тэдний саналд үндэслэн шийдвэр гаргадаг болно.	1.1.2.2. Иргэдийн дунд нутаг дэвсгэрийн хэмжээнд хийгдэх хөрөнгө оруулалт, бусад тулгамдаж буй асуудлаар 2-оос доошгүй санал асуулга явуулж дүнг төсөл хөтөлбөрт тусган хэрэгжүүлэх	Жилдээ	Засаг дарга БХМ	Хөрөнгө шаардахгүй
4.		1.1.2.3.Санал асуулгын дүнг үндэслэн иргэдээр хэлэлцүүлж хөтөлбөр төсөл арга хэмжээг эрэмбэлж тухайн жилд санхүүжүүлэх шийдвэр гаргах	Жилдээ	Засаг дарга ЗДТГ-ын дарга	Хөрөнгө шаардахгүй

ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ЭМХТГЭЛ | 2014

				БХМ Багийн Засаг дарга нар	
5.		1.1.2.4. Шинээр гарч буй хууль тогтоомж болон хуульд орсон нэмэлт өөрчлөлт хийж иргэдэд зөвлөмж өгөх, эрх зүйн туслалцаа үзүүлэх.	Жилдээ	ЗДТГ-ын дарга ХЗАХМ	Хөрөнгө шаардахгүй
6.	1.1.3. Сум багийн үйл ажиллагааг ил тод болгож холбогдох шийдвэрүүдийг онлайн болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр тогтмол мэдээлж хяналт тавих эрхийг иргэдэд олгоно.	1.1.3.1.Багийн ИНХ-ыг жилд 2-оос доошгүй удаа хуралдуулж багийн Засаг дарга, Өрхийн эрүүл мэндийн төв, Цагдаагийн хэсгийн тайлан хэлэлцүүлж үнэлэлт дүгнэлт өгөх	Хагас бүтэн жилээр	Засаг дарга БХМ Багийн Засаг дарга нар	Хөрөнгө шаардахгүй
7.		1.1.3.2. Сумын ЗДТГ, багаас хэрэгжүүлж буй ажил арга хэмжээ, хөтөлбөр төслийн хэрэгжилтийг онлайн болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр тогтмол сурталчлах	Улирал бүр	Хэвлэл мэдээлэл хариуцсан ажилтан Багийн Засаг дарга нар	ЗДТГ-ын төсвөөс
8.		1.1.3.3. Сумын ЗДТГ веб сайтаар баг бүр танилцуулга, бодлого шийдвэр, ажлын үр дүнг сурталчлах иргэдийн санал хүсэлтийг хүлээн авах	Улирал бүр	Хэвлэл мэдээлэл хариуцсан ажилтан Багийн Засаг дарга нар	Хөрөнгө шаардахгүй
9.		1.1.3.4. Иргэдийн өргөдөл санал гомдлыг нээлттэй утсаар авах, иргэдээс ирүүлж буй өргөдөл, гомдол, санал хүсэлтийг судлан хуулийн дагуу шуурхай хариу өгөх	Сар бүр	Засаг даргын нарийн бичиг Багийн Засаг дарга нар	Хөрөнгө шаардахгүй
10.		1.1.3.5. “Цахим-Баян-Өндөр”сүм хөтөлбөрийг үе шаттай хэрэгжүүлж сум, багийг цахим, онлайн системд холбож, “Иргэн төвтэй” төрийн цахим үйлчилгээг бий болгох.	Жилдээ	Хэвлэл мэдээллийн ажилтан	Хөрөнгө шаардахгүй
11.		1.1.3.6.МУ-ын Засгийн газраас батлагдсан Багийн хөгжлийг	Жилдээ	БХМ	Хөрөнгө шаардахгүй

ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ЭМХТГЭЛ | 2014

		дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллах ажи			
12.		1.1.3.7.Аймгийн баг хөгжүүлэх дэд хөтөлбөрийн биелэлтийг хангуулж ажиллах	Жилдээ	БХМ	Хөрөнгө шаардахгүй
13.	1.1.4. “Төсвийн ил тод байдал”-ыг хангах авилга хээл хахуулийг халах зорилгоор төсвийн мөнгөөр бараа үйлчилгээ	1.1.4.1.Сум, багийн эдийн засаг, нийгмийн хэтийн хөгжил, хөрөнгө оруулалтыг тооцон төсвийг зардлын зүйл ангиар төлөвлөх, хуваарийн дагуу зарцуулж ил тод тайлагнах	Жилдээ	Засаг дарга ЗДТГ-ын дарга Ня-бо	Хөрөнгө шаардахгүй
14.	худалдан авах үйл ажиллагааг онлайн хэлбэрт шилжүүлж, ТББ иргэдийн оролцоотой ил тод явуулна.	1.1.4.2.Хөрөнгө оруулалт, тоног төхөөрөмж, бараа ажил үйлчилгээг худалдан авах үйл ажиллагааг нээлттэй, шударга, ил тод хуулийн дагуу явуулж, хяналтыг сайжруулах	Жилдээ	Засаг дарга ЗДТГ-ын дарга Ня-бо	Хөрөнгө шаардахгүй
15.		1.1.4.3.Төсвийн гүйцэтгэл, бараа ажил үйлчилгээ худалдан авах ажлын зар мэдээг хэвлэл мэдээлэл, онлайн хэлбэрээр иргэдэд нээлттэй шуурхай хүргэх	Жилдээ	Засаг дарга ЗДТГ-ын дарга Ня-бо	Хөрөнгө шаардахгүй
16.		1.1.4.4.Төсвийн хөрөнгө оруулалтыг олон нийтийн оролцоонд тулгуурлан жил бүр төлөвлөх	Жилдээ	ЗДТГ	Орон нутгийн төсвөөс
17.	1.1.5. Орон нутгийн хөгжлийн сангийн журмыг баталж олон нийтийн хяналтын зөвлөл байгуулан ажиллана.	1.1.5.1.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг төсвийн тухай хууль, журмын дагуу зарцуулах	Жилдээ	Засаг дарга ЗДТГ-ын дарга Ня-бо	Хөрөнгө шаардахгүй
18.		1.1.5.2.Хөрөнгө оруулалт хөтөлбөр төсөл арга хэмжээг иргэд олон нийтийн саналыг эрэмбэлэн жил бүрийн төсвийн төсөлд тусган санхүүжүүлэх	Жилдээ	Засаг дарга ЗДТГ-ын дарга Ня-бо	
19.	1.1.6 Цахим сум хөтөлбөрийг хэрэгжүүлж төрийн үйлчилгээг	1.1.6.1.Иргэдээс цахим хэлбэрээр ирсэн өргөдөл санал гомдол хүлээн авах, шийдвэрлэсэн тухай хариу мэдээлэх	Жилдээ	ЗДТГ	Хөрөнгө шаардахгүй

ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ЭМХТГЭЛ | 2014

20.	чирэгдэлгүй болгон төрийн нууцаас бусад шийдвэр байгууллагын мэдээллийг ил тод болгоно.	1.1.6.2.Нийтийн болон нийтлэг үйлчилгээг иргэдэд ойртуулах зорилгоор цахим үйлчилгээний мэдээллийн төвийг баг бүрт бий болгох.	Жилдээ	ЗДО Багийн Засаг дарга нар	Багийн хөгжлийн сангаас
21.	1.1.7. Төр, хувийн хэвшлийн түншлэл хамтын ажиллагааг хөгжүүлж төрийн зарим ажил үйлчилгээг төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр гүйцэтгүүлж төрийн албыг нийтийн алба болгох бэлтгэл ажлыг эхлүүлнэ.	1.1.7.1.Иргэний нийгмийн байгууллага Төрийн бус байгууллагыг идэвхжүүлэх, гэрээ байгуулан тохижилт, сургалт, байгаль орчныг хамгаалах чиглэлээр хамтран ажиллах	Жилдээ	ЗДТГ	Төрийн болон ТББ-н оролцоотой
22.		1.1.7.2.Иргэдэд өдөр тутам үйлчилдэг нийтийн албан хаагчдыг иргэд өөрсдөө үнэлдэг журамд оруулж, цалин хангамжийг ажлын бүтээмжтэй уялдуулан тооцож, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах	Жилдээ	Засаг дарга ЗДО ЗДТГ-ын дарга	Хөрөнгө шаардахгүй
23.	1.1.8. Сумын гадаад болон дотоод харилцааг шинэ шатанд гаргаж харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлж хөрөнгө оруулах чиглэлээр хамтран ажиллана.	1.1.8.1.Нийслэлийн дүүрэг, аймгийн төвийн сумын ЗДТГ, баг хороодын ажлын туршлага судлах, шинэлэг, үр дүнтэй ажлаас суралцах	Жилдээ	Засаг дарга ЗДТГ-ын дарга	Засаг даргын нөөц сангаас ЗДТГ-ын төсвөөс
24.		1.1.8.2.Уламжлалт харилцаатай болон гадаад орны хотуудтай харилцан ажиллах, талаар гэрээ хэлцэл байгуулах	Жилдээ	Засаг дарга ЗДТГ-ын дарга	Засаг даргын нөөц сангаас
25.	1.1.9. Аймаг сумын ажлын уялдаа холбоог сайжруулан үйл ажиллагааны чиглэл хариуцлагын тогтолцоог тодорхой болгоно.	1.1.9.1. Засаг даргын Тамгын газрын орон тоо, бүтцийг шинэчлэн ажлын байрны тодорхойлолтод өөрчлөлт оруулах	Жилдээ	Засаг дарга ЗДТГ-ын дарга	Хөрөнгө шаардахгүй
26.		1.1.9.2. “Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх.	Жилдээ	ЗДТГ-ын дарга ДАХА	Засаг даргын нөөц сан ЗДТГ-ын төсөв Орон нутгийн төсвөөс
27.	1.1.10.Төрийн үйлчилгээг иргэдэд ойртуулах чанарын стандартыг хэрэгжүүлэх боломж	1.1.10.1. ISO 9001 чанарын удирдлагын тогтолцоог сумын ЗДТГ-т нэвтрүүлэх	Жилдээ	ТГ-ын дарга	Орон нутгийн төсвөөс

ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ЭМХТГЭЛ | 2014

	нөхцөлийг бүрдүүлэх				
28.	1.1.11. Багийн хөгжлийг дэмжин, ажиллах боловсон хүчнийг чадваржуулж, иргэдэд үйлчилгээг шуурхай хүргэх нөхцөлийг бүрдүүлнэ.	1.1.11.1. Баг бүр нутаг дэвсгэрт хэрэгжүүлэх зорилт дэвшүүлэн бүтээмжийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх.	Жилдээ	Засаг дарга ЗДТГ	Орон нутгийн төсвөөс
29.		1.1.11.2.Төрийн үйлчилгээний нэгдсэн байранд иргэний танхимыг шинээр байгуулах	Жилдээ	Засаг дарга ЗДТГ	Орон нутгийн төсвөөс
30.		1.1.11.3. Шинээр байгуулагдсан Яргуйт багт баг, цагдаа, өрхийн эрүүл мэндийн төв, Нэг цонхны үйлчилгээ бүхий цогцолбор байр барих	Жилдээ	Засаг дарга ЗДТГ	Орон нутгийн төсвөөс
ХОЁР. ЭРДЭМ БОЛОВСРОЛТОЙ ИРГЭДТЭЙ ОЮУНЛАГ ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМ					
2.Боловсролын байгууллагын үйл ажиллагааг шинэчлэл хийх чиглэлээр:					
31.	2.1.1.Цэцэрлэгийн насны хүүхдийн хүмүүжих, сурч боловсрох таатай орчин бүрдүүлж материаллаг баазаар хангана.	2.1.1.1.Цэцэрлэгүүдийг сургалтын хэрэгсэл, багаж төхөөрөмж, тоглоомоор хангах, материаллаг нөхцөлийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх	Жилдээ	Засаг дарга БСЭМАХА	Орон нутгийн хөрөнгө оруулалтаар Төслийн байгууллага
32.					
33.	2.1.2. Ерөнхий боловсролын шинэ стандартыг хэрэгжүүлж сургуулийн өмнөх боловсрол олгох, хамран сургалтыг нэмэгдүүлнэ.	2.1.2.1. Эрдэнэ багт баригдах сургуулийг эхлүүлэх, Их залуу багт 640 хүүхдийн багтаамжтай сургуулийг ашиглалтад оруулах	Жилдээ	ЗДО БСЭМАХА	Улсын төсөв
34.		2.1.2.2. 6 настай хүүхдүүдийг сургуульд хамруулах сургалтыг сайжруулах, сурах нөхцөлийг бүрдүүлэх	Жилдээ	Засаг дарга БСЭМАХА	Хөрөнгө шаардахгүй
35.		2.1.2.3. Сурлага, урлаг, спортоор онцгой амжилт гаргасан сурагчдыг шагнаж урамшуулах	Жилдээ	Засаг дарга БСЭМАХА	Засаг даргын нөөц сан

ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ЭМХТГЭЛ | 2014

1.1.11	агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамж	
1.2.	Сум/дүүргийн төсвийн татварын бус орлого	0.0
1.2.1	орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн орон нутгийн өмчид ногдох хувьцааны ногдол ашиг	
1.2.2	орон нутгийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр	
1.2.3	хүү, торгуулийн орлого	
1.2.4	Төсөвт байгууллагын өөрийн орлого	
1.2.5	хууль тогтоомжийн дагуу аймаг, нийслэлийн төсөвт төвлөрүүлэх бусад орлого.	
1.2.6	Өмч хувьчлалын орлого	
2.	Хөрөнгийн орлого	
2.1	Хөрөнгө борлуулсны орлого	
3.	Тусламжийн орлого	0.0
3.1	Хандив тусламжийн орлого	
3.2	Санхүүгийн дэмжлэг	
3.3	Орон нутгийн хөгжлийн сан орлогын шилжүүлэг	
3.4	Тусгай зориулалтын шилжүүлэг	
..	...	

2. Баян-Өндөр сумын 2015 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч, түүний харьяа байгууллага, бусад байгууллагын төвлөрүүлэх орлогын хэмжээг дор дурьдсанаар баталсугай.

/мянган төгрөг/

2.1.	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга	0.00
2.1.1	Харьяалах төсөвт байгууллагын өөрийн орлого	
2.2.	Засаг дарга	0.00
2.2.1.	Харьяалах төсөвт байгууллагын төсөвт төвлөрүүлэх орлого	
2.2.2.	Харьяалах төсөвт байгууллагын өөрийн орлого	
2.3.	Сургуулийн захирал/Цэцэрлэгийн эрхлэгч (г.м)	
2.3.1	Харьяалах төсөвт байгууллагын өөрийн орлого	

2.4.	... Г.М	
2.4.1	...	

3. Баян-Өндөр сумын 2015 оны орон нутгийн төсвийн зарлагын нийт дүн, Төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн жилд зарцуулах зарлагын дээд хэмжээг дор дурьдсанаар баталсугай.

/мянган төгрөг/

3.1.	Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга	90 496.0
3.1.1.	Урсгал зардлын дээд хэмжээ	90 496.0
3.1.2.	Хөрөнгийн зардлын дээд хэмжээ	
3.2.	Засаг дарга	4189311.6
3.2.1	Урсгал зардлын дээд хэмжээ	1 158 087.8
3.2.1.1.	Үүнээс: сум/дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй улсын төсөвт байгууллагад олгох тусгай зориулалтын шилжүүлгийн хэмжээ	0.0
3.2.1.2.	Аймаг, нийслэлийн орон нутгийн хөгжлийн санд төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээ	3.001.223.8
3.2.1.3	Засаг даргын нөөц сан	30 000.0
....	Г.м Зээлийн сан / сум хөгжүүлэх /	х
3.2.2	Хөрөнгийн зардлын дээд хэмжээ	4 279 807.6

4.Тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжих төсөвт байгууллагын зардлын хэмжээг дор дурдсанаар баталсугай:

/мянган төгрөг/

4.1.	1-сургууль	0.00
4.2	2-р сургууль	
4.3	1-р цэцэрлэг	
4.4	Сумын эмнэлэг	
4.5	Соёлын төв	
4.6	Номын сан	

5.Сумаас аймгийн төсөвт төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээг 0,0 мянган төгрөгөөр баталсугай.

6.Урьд оны үлдэгдлээс санхүүжих урсгал зардлын дүнг 0,0 мян төг, хөрөнгийн кардлын дүнг 0,0 мян төгрөгөөр баталсугай.

7.Сумын ЗДТГ, багуудад батлагдсан төсвийг зардлын зүйл ангиар, сар улирлаар хуваарийн дагуу зарцуулан, гүйцэтгэлийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сар бүр ил тод мэдээллэх, хагас жилээр Тэргүүлэгчдийн хуралдаанд, жилийн эцэст Хурлын хуралдаанд танилцуулахыг Засаг дарга /И.Баасанжав/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Н.ЖАРГАЛСАЙХАН



**ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 6 ДАХЬ УДААГИЙН
СОНГУУЛИЙН ЭЭЛЖИТ XIII ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2014 оны 12 сарын 12 өдөр

Дугаар 05

Эрдэнэт

Сум хөгжүүлэх сангийн тэргүүлэх чиглэл,
дотоод журмыг шинэчлэн батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 дахь заалт, Засгийн газрын 2011 оны 134 дүгээр тогтоолын I зүйлийн 1.6 дахь заалт, 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх заалтыг үндэслэн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ээлжит XIII хуралдаанаар хэлэлцээд ТОГТООХ нь:

1.Сум хөгжүүлэх сангийн хөрөнгөөр зээл олгохтой холбогдуулан сумын хөгжлийн тэргүүлэх чиглэлийг I хавсралтаар, дотоод журмын өөрчлөлтийг II хавсралтаар тус тус баталсугай.

2.Тогтоолыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, гүйцэтгэлийг жилийн эцэст хурлын хуралдаанд тайлагнахыг сумын Засаг дарга /И.Баасанжав/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Н.ЖАРГАЛСАЙХАН

Орхон аймгийн Баян-Өндөр сумын ИТХ-ын
2014 оны 12 сарын 12 өдрийн ээлжит 13 дүгээр
хуралдааны 05 дүгээр тогтоолын 01 дүгээр хавсралт

2015 ОНЫ “СУМ ХӨГЖҮҮЛЭХ САН”-ГИЙН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ

Аймаг, сумын Засаг даргын 2013-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр, “Сум хөгжүүлэх сан”-аас 2014 онд тэргүүлэх чиглэлд тусгагдаагүй эрэлттэй байсан чиглэл, Засгийн газрын 2014 оны 279 дүгээр тогтоолоор баталсан “Ахуйн үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр” зэрэгт тулгуурлан дараах чиглэлүүдийг санал оруулж байна.

Үүнд:

1. Хүнс, хөдөө аж ахуйн чиглэлийн хүрээнд: Эрчимжсэн мал аж ахуй, тахиа, гахайн аж ахуй, жимс жимсгэнийг тариалалт, малын тэжээлийн тариалалт, өвөл, зуны хүлэмж, цэцэрлэгжүүлэлт, “Эрдэнэт” хотын шинж чанарыг тусгасан брэнд бүтээгдэхүүн

2. Боловсруулах үйлдвэрлэл: Гурил тэжээлийн үйлдвэр, жимс, чацаргана боловсруулах үйлдвэрлэл, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, оёдол, хувцас захиалга засвар сүлжмэл, арьс ширэн бүтээгдэхүүн, гутал үйлдвэрлэл, гутал засвар, талх нарийн боовны үйлдвэрлэл, хүнсний зориулалттай байгальд ээлтэй уутны үйлдвэрлэл, мод модон бүтээгдэхүүн, сэлбэгийн үйлдвэрлэл

3. Барилгын материал үйлдвэрлэл: Шахмал түлш, хөнгөн блок, дулаалгын материал үйлдвэрлэл, ган хийц, хуванцрын үйлдвэрлэл,

4. Боловсролын чиглэлээр: Цэцэрлэгийн сургалтын хэрэгсэл, тоглоомын үйлдвэрлэл, хүүхдийн өдөр өнжүүлэх, цэцэрлэгийн үйлчилгээ

5. Эрүүл мэндийн чиглэлээр: Хүүхэд, өндөр настны эмнэлэг, сувилал, эмийн сан /Алслагдсан багуудад/

6. Гэр хорооллын алслагдсан багуудад нийтийн ахуйн үйлчилгээ /Халуун ус, үсчин/

7. Үйлчилгээний чиглэлээр: Авто засвар, нийтийн биеийн тамир, хэвлэл дизайн, нийтийн хоолны газар, гэрэл зураг, компьютерийн үйлчилгээ, гэр ахуйн цахилгаан хэрэгсэл, гар утасны засварын үйлчилгээ, түлхүүр хувилах үйлчилгээ

ООо

Орхон аймгийн Баян-Өндөр сумын ИТХ-ын
2014 оны 12 сарын 12 өдрийн ээлжит 13 дүгээр
хуралдааны 05 дүгээр тогтоолын 02 дүгээр хавсралт

БАЯН-ӨНДӨР СУМЫН СУМ ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН ДОТООД ЖУРАМ

1. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журам нь суманд жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээ, хоршоог хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх зорилгоор Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавихтай холбоотой үүссэн харилцааг зохицуулахад оршино.

1.2. Сан нь төрийн санд тусгай данстай байх бөгөөд гадуур данстай байхыг хориглоно.

1.3. Сангийн орлого зарлага нь сумын төсвийн гүйцэтгэлийн сар бүрийн мэдээ улирал жилийн тайлан тэнцэлд тусгагдана.

1.4. Иргэн, жижиг дунд үйлдвэр эрхлэгчдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх зорилго бүхий сум хөгжүүлэх сангаас олгох хөнгөлөлттэй зээл нь дараах нөхцөлтэй байна.

1.4.1 Хөнгөлөлттэй зээлийн хүүгийн хэмжээ жилд 2,8 хувь

1.4.2 Зээлийн хугацаа нь 36 сар хүртэл

1.4.3 Нэг төсөлд олгох зээлийн дээд хэмжээ иргэнд 10,0 сая төгрөг хүртэл, ЖДҮ эрхлэгч, нөхөрлөл, хоршоонд 15,0 сая төгрөг хүртэл

1.4.4 Зээлдэгч зээлийг хугацаандаа төлөөгүй, эсвэл зээлийн хөрөнгийн зориулалт бусаар зарцуулсан бол зээлийн төлөгдөөгүй үлдэгдэлд торгууль ногдуулж төлүүлнэ. Торгуулийн хувь хэмжээг зээлийн төлөгдөөгүй үлдэгдэлд хоногийн 0,1% -аар тооцож, дансанд төвлөрүүлж, зээлийн эх үүсвэрт зарцуулна.

1.4.5 Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сан, өрхийн үйлдвэрлэлийг дэмжих сан, сум хөгжүүлэх сангаас урьд авсан зээлийн өргүй, арилжааны банк, бусад санхүүгийн байгууллагад бизнесийн зээлийн өргүй байх, цалин, тэтгэвэр, санхүүгийн түрээс гэх мэт бусад зээлийн үлдэгдэл нь хүсэж буй зээлийн 50%-иас дээшгүй байх

1.4.6 Зээлийг олгохдоо зээлдэгчтэй зээлийн гэрээ болон барьцааны гэрээ, баталгааны гэрээ байгуулан олгох

1.4.7 Зээлийн хэмжээнд тохирсон хөрөнгийг барьцаалах

1.4.8 Тухайн зээлдэгч өөрийн барьцаалах хөрөнгө байхгүй тохиолдолд гуравдагч этгээдийн үл хөдлөх хөрөнгийг хууль тогтоомжийн дагуу

барьцаанд тавьж болно.

1.5. Сум хөгжүүлэх сангийн төсөл сонгон шалгаруулах зөвлөл нь дараах бүрэлдэхүүнтэй байна.

1.5.1 Зөвлөлийн ахлагч – Сумын Засаг дарга

1.5.2 Зөвлөлийн гишүүд нь сумын ЗДТГ –ын 3 мэргэжилтэн, тухайн сумын 3 иргэний төлөөлөл байна.

1.5.3 Зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт орсон тохиолдолд сонгон шалгаруулалт хийж , сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлж батлуулна.

1.5.4 Зөвлөл нь Сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагааны нягтлан бодох бүртгэлийг хууль тогтоомжийн дагуу хөтөлж, санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан гаргах, сангийн хөрөнгийн зарцуулалт, ашиглалт, зээлийн эргэн төлөлттэй холбоотой мэдээлэл гаргах, хяналт тавих, төрийн сантай харилцах ажлыг хариуцсан нягтлан бодогчтой байна.

2. Зөвлөлийн удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагаа

2.1. Зөвлөлийн ахлагч сангийн үйл ажиллагаатай холбогдсон дараах эрх үүргийг хэрэгжүүлнэ.

2.1.1 Зөвлөлөөс шалгаруулсан төсөлд зээл олгох шийдвэр гаргах

2.1.2 Төсөл нь шалгарсан иргэн аж ахуйн нэгжтэй зээлийн гэрээ байгуулж, гэрээний биелэлтийг хангуулах ажил зохион байгуулж, хэрэгжилтийн явц үр дүнд байнгын хяналт тавьж ажиллах

2.1.3 Зээлийн хүүгийн орлогоос зээлийн ашиглалт, эргэн төлөлтөд хяналт тавих үйл ажиллагаанд зарцуулах хөрөнгийн төсвийг боловсруулж иргэдийн төлөөлөгчийн хурлаар хэлэлцүүлэн, сумын жил бүрийн төсөвтэй хамт батлуулах

2.1.4 Сангийн үйл ажиллагааны үр дүнг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын өмнө хариуцах

2.1.5 Багийн Засаг дарга нарыг үүрэгжүүлэх

2.2. Зөвлөлийн нарийн бичиг сангийн үйл ажиллагаатай холбогдсон дараах эрх үүргийг хэрэгжүүлнэ.

2.2.1 Өргөдлийн маягтыг хүлээн авч бүртгэлжүүлэх

2.2.2 Сангийн хөрөнгийн зарцуулалт, ашиглалт, зээлийн эргэн төлөлттэй холбоотой мэдээллийг улирал бүрийн сүүлийн 25-ны дотор гаргаж аймгийн Хөдөлмөрийн хэлтэст хүргүүлэх

2.2.3 Зээлдэгчийн талаар гаргасан багуудын төрөлжсөн судалгааны дагуу айл өрх, аж ахуй нэгжээр биечлэн орж, мэдээний үнэн бодит байдалд хяналт тавих

2.2.4 Төсөл нь тэнцээгүй иргэдэд хариуг бичгээр хүргүүлж, тайлбар хийх

2.2.5 Өргөдлийн хариуг багийн Засаг даргаар дамжуулан хүргүүлэх

2.2.6 Зөвлөлийн хурлын тэмдэглэлийг хөтөлж, баримтжуулах

2.2.7 Зээлдэгчийн барьцаанд бариулсан хөрөнгийн бичиг баримтын эх хувийг авч, бүрэн бүтэн байдлыг хангах

2.3. Зөвлөлийн гишүүд сангийн үйл ажиллагаатай холбогдсон дараах эрх үүргийг хэрэгжүүлнэ.

2.3.1 Зөвлөлийн гишүүд нь өргөдөл, төслүүдийг хүлээн авч газар дээр нь очиж танилцан, үнэлгээ хийх.

2.3.2 Улс, орон нутгийн бодлого, чиглэлд уялдуулан сонгон шалгаруулалтыг хийх

2.3.3 Зөвлөлийн гишүүн нь ашиг сонирхлын зөрчилтэй гэж үзвэл санал өгөхөөс татгалзах эрхтэй.

2.3.4 Зээлийн эргэн төлөлт хүндэрч хэвийн бус ангилалд шилжсэн тохиолдолд зөвлөлийн гишүүдийг зээл эргэн төлүүлэх арга ажиллагаанд татан оролцуулна.

2.3.5 Иргэний төлөөллийн урамшуулал нь “Сум хөгжүүлэх сан”-гийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журмын 1.8 дахь заалтын зарцуулах эрхийн мөнгөн дүнгийн 10 %-аас багагүй байна.

2.4 Багуудын ажлын алба сангийн үйл ажиллагаатай холбогдсон дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

2.4.1 Багийн нийгмийн ажилтан сумын нарийн бичгийн хүлээлгэн өгсөн өргөдлийн маягтыг бодит байдал дээр нь очиж судалж, маягт дахь хэсэгт тодорхойлолтыг бичих

2.4.2 Багийн Засаг дарга тодорхойлолттой танилцаж үнэн бодитой эсэхийг тамга тэмдгээр баталгаажуулан зөвлөлийн нарийн бичигт хүргүүлнэ.

2.4.3 Сангаас зээл авсан иргэн, аж ахуй нэгжүүдэд багийн нийгмийн ажилтан хяналт тавьж, тухай бүр зээлдэгчийн судалгааг гаргаж зөвлөлийн нарийн бичигт хүргүүлж байх

2.4.4 Төсөл сонгон шалгаруулах хуралд тухайн зээлдэгчийн харьяалагдах багийн нийгмийн ажилтан ирж тухайн зээлдэгчийн үйл ажиллагааг тодорхойлох

3. Төсөл сонгон шалгаруулах

3.1. Төсөл сонгон шалгаруулах зөвлөл нь Засгийн газрын 2011 оны 134 дүгээр тогтоолоор баталсан Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журмын 4 дүгээр зүйлийг баримтлан ажиллана.

3.2. Хөрөнгийн эх үүсвэрээс шалтгаалан хүлээн авах өргөдлийн тоог зөвлөлийн гишүүд хэлэлцэн шийдвэрлэнэ.

3.3. Төсөл сонгон шалгаруулах зөвлөл нь дараах үе шаттайгаар төслийг сонгон шалгаруулна.

3.3.1 Өргөдлийг маягтыг зөвлөлийн нарийн бичиг иргэн, аж ахуйн нэгжээс хүлээн авах, шаардлага хангахгүй өргөдлийг өргөдөл гаргагчид буцаах,

3.3.2 Бүртгэсэн өргөдлүүдээ харьяа багийн Засаг дарга нарт хүлээлгэн өгч тодорхойлолт гаргуулах

3.3.3 Тодорхойлолт гаргасан өргөдлүүдийг зөвлөлийн хурлаар хэлэлцэж үнэлгээ хийж, төсөл ирүүлэх иргэн, аж ахуйн нэгжийг тодруулах

3.3.4 Зөвлөлийн гишүүд танилцсан төслүүдийг хурлаар хэлэлцүүлэн олонхын саналаар сонгон шалгаруулна.

3.3.5 Шалгарсан төслүүдэд сумын Засаг дарга захирамж гарган, зээлдэгчтэй зээлийн гэрээ барьцааны гэрээ болон баталгааны гэрээ байгуулан зээлийг олгоно.

Жич: Санхүүжилтийн хэмжээнээс хамаарч өргөдөл, төслийг нэг хурлаар шийдвэрлэж болно.

3.4 Олонхын санал авсан төсөл гэдэгт ирцийн 60% ба түүнээс дээш гишүүдийн санал авсан төслийг хамааруулж ойлгоно.

3.5 Төсөл сонгон шалгаруулах хурлыг гишүүдийн 71% хувийн ирцтэй тохиолдолд хийнэ.

3.6 Төсөл сонгон шалгаруулах зөвлөл нь сангаас зээл хүссэн иргэн аж ахуйн нэгжийн боловсруулсан төслийг сонгон шалгаруулахдаа дараах шалгуурыг харгалзан үзнэ.

3.6.1 Сумын ИТХ –с баталсан сумын хөгжлийн тэргүүлэх чиглэлд нийцсэн байх

3.6.2 Тухайн суманд жижиг, дунд үйлдвэрлэл хөгжүүлэх бодлогын хүрээнд орон нутгийн давуу талд түшиглэсэн үйлдвэрлэл, үйлчилгээг бий болгох, орон нутагт тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэхэд чиглэгдсэн байх

3.6.3 Хүрэх үр дүн, зорилт нь тодорхой байх

3.6.4 Төслийн үр ашиг, гэрээний хугацаанд зээлээ эргэн төлөх боломжтой байх

3.6.5 Төслийг хэрэгжүүлэх явцад учирч болзошгүй эрсдэлийг бодитой тодорхойлсон, эрсдэлийг даван туулах талаар тусгасан байх

3.6.6 Ажлын байр нэмэгдүүлэхэд чиглэсэн байх

3.7 Сангийн хөрөнгөөс зээл авч төсөл хэрэгжүүлэх этгээд нь дараах шаардлагыг хангасан байна.

3.7.1 Арилжааны банк болон бусад санхүүгийн байгууллагад бизнесийн зээлийн өргүй байх

3.7.2 Үйл ажиллагаагаа өргөтгөх, нэмэгдүүлэх зорилготой иргэн, аж ахуй нэгжүүд жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчээр бүртгэгдсэн байх.

3.7.3 Зөвлөлийн хурлаар баталсан зээлийн гэрээний 2.6 дахь заалтын шалгуур хангасан батлан даагчтай байх

3.7.4 Зээлийн хэмжээнд тохирсон барьцаатай байх. Барьцаа хөрөнгийн баримт бичгийн эх хувийг Сум хөгжүүлэх санд байршуулах

4. Хариуцлагын тухай

4.1 Батлан даагч нь зээлдэгчийн зээлийн зарцуулалт, нөхөн төлөлт, үйл ажиллагаанд хяналт тавих бөгөөд үүргээ биелүүлээгүй тохиолдолд баталгааны гэрээнд заасны дагуу зээлдэгчийн өмнөөс бүрэн хариуцлага хүлээнэ.

4.2 Зээлдэгч зээлийг үр ашиггүй зарцуулсан эсхүл зээлийн гэрээнд заасан зориулалтын дагуу зарцуулаагүй, зээл, түүний хүүг гэрээний хугацаа хэтрүүлж төлсөн, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй зэрэг тохиолдолд тухайн иргэн, аж ахуй нэгж нь зээлийн гэрээ болон барьцааны гэрээнд заасны дагуу хариуцлага хүлээнэ.

4.3 Зээлдэгч, хамтран үүрэг гүйцэтгэгч нь гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн тохиолдолд холбогдох этгээдэд мэдэгдэх, тайлагнах

4.4 Сангийн хөрөнгийг зарцуулах зээл олгох, зээлийн хөрөнгийг ашиглах, хяналт тавих, тайлагнах үйл ажиллагааны талаар энэхүү журмаар тогтоосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

oOo



**ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 6 ДАХЬ УДААГИЙН
СОНГУУЛИЙН ЭЭЛЖИТ XIII ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2014 оны 12 сарын 12 өдөр

Дугаар 06

Эрдэнэт

Сум хөгжүүлэх сангийн 2014 оны үйл ажиллагааг үнэлэх,
2015 оны үйл ажиллагааны төсөв батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 дахь заалт, Засгийн газрын 2011 оны 134 дүгээр тогтоолын 1.8 дахь заалт, 3.2.6 дахь заалтыг тус тус үндэслэн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ээлжит XIII хуралдаанаар хэлэлцээд ТОГТООХ нь:

1.Сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагааг ХАНГАЛТТАЙ гэж дүгнэсүгэй.

2.Сум хөгжүүлэх сангийн төсөл сонгон шалгаруулах, зээлийн ашиглалт, эргэн төлөлтөнд хяналт тавих ажлыг зохион байгуулах, зөвлөлийн үйл ажиллагаанд 2015 онд зарцуулах төсвийг хавсралтаар баталсугай.

2.Батлагдсан төсвийг журмын дагуу зарцуулж, санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг хагас, бүтэн жилээр хурлын хуралдаанд тайлагнахыг сумын Засаг дарга /И.Баасанжав/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Н.ЖАРГАЛСАЙХАН

ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ЭМХТГЭЛ | 2014

Орхон аймгийн Баян-Өндөр сумын ИТХ-ын
2014 оны ... сарын .. өдрийн ээлжит ... дугаар
хуралдааны ... дугаар тогтоолын ... дүгээр хавсралт

БАЯН-ӨНДӨР СУМЫН СУМ ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН 2015 ОНЫ ТӨСВИЙН ХУВААРЬ

Бүтээгдэхүүний нэр төрөл/Зардлын зүйл ангиар/	Нийт төсөв /жил/	Сараар						Эхний хагас жилийн дүн	Сараар						Сүүлийн хагас жилийн дүн
		1	2	3	4	5	6		7	8	9	10	11	12	
Зөвлөлийн 3 иргэний төлөөллийн урамшуулал /22456/	1440000			360000			360000	720000			360000			360000	720000
Багийн хяналтын үйл ажиллагаанд /22443/	2520000			630000			630000	1260000			630000			630000	1260000
Эрсдэлийн сан /22564/	3000000		3000000					3000000							0
Бичиг хэрэг, хор/22301/	720000	100000	40000	40000	100000	40000	40000	360000	100000	40000	40000	100000	40000	40000	360000
Шатахуун /22302/	1200000	100000	100000	100000	100000	100000	100000	600000	100000	100000	100000	100000	100000	100000	600000
Харилцаа холбоо /22303/	360000	30000	30000	30000	30000	30000	30000	180000	30000	30000	30000	30000	30000	30000	180000
Мэдээлэл сурталчилгаа /22432/	1350000			300000			300000	600000			300000	150000	150000	150000	750000
Үзэсгэлэн худалдаа /22401/	3000000		1500000					1500000	1500000						1500000
Сургалт зохион байгуулах /22307/	800000		800000					800000							0

ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ЭМХТГЭЛ | 2014

Хөтөлбөр болон төслийн дотоод урсгал зардал /22541/	200000	0	50000	0	0	50000	0	100000	0	50000	0	0	50000	0	100000
Нийт дүн	14590000	230000	5520000	1460000	230000	220000	1460000	9120000	1730000	220000	1460000	380000	370000	1310000	5470000



**ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 6 ДАХЬ УДААГИЙН
СОНГУУЛИЙН ЭЭЛЖИТ XIII ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2014 оны 12 сарын 12 өдөр

Дугаар 07

Эрдэнэт

2014 оны ОНХС-ийн төсвөөс санхүүжүүлэх
хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний жагсаалтад нэмэлт тодотгол
оруулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2.б дэх заалт, Төсвийн тухай хуулийн 64.1.2, 66 дугаар зүйлийн 66.1.1 дэх заалт, сумын Засаг даргын саналыг тус тус үндэслэн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ээлжит XIII хуралдаанаар хэлэлцээд ТОГТООХ нь:

1.ОНХС-гийн хөрөнгө оруулалтаар Женекон ХХК-ийн хийж гүйцэтгэсэн дээвэр засварын ажлын 2014 оны дутуу санхүүжилт 116 378 600 /Нэг зуун арван зургаан сая гурван зуун далан найман мянга зургаан зуун/ төгрөгөөс 3 0000 000 /Гучин сая/ төгрөгийг 2014 онд батлагдсан хөрөнгө оруулалт хөтөлбөр төсөл арга хэмжээний гүйцэтгэлийн хэмнэлтээс тодотгон, хавсралтаар баталсугай.

2.Тогтоолыг хэрэгжүүлж, биелэлтийг тайлагнахыг сумын Засаг дарга /И.Баасанжав/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Н.ЖАРГАЛСАЙХАН



**ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 6 ДАХЬ УДААГИЙН
СОНГУУЛИЙН ЭЭЛЖИТ XIV ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2014 оны 12 сарын 30 өдөр

Дугаар 02

Эрдэнэт

**Сумын газар зохион байгуулалтын
төлөвлөгөө батлах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18, 25 дугаар зүйлүүд, Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2 дахь заалтыг үндэслэн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ээлжит XIV хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Сумын 2015 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөг I, II, III, IV хавсралтаар баталсугай.

2.Иргэдэд газар өмчлүүлэх ажлыг хуулийн хүрээнд зохион байгуулж, төлөвлөгөөний биелэлт, зохион байгуулсан ажлын үр дүнг хагас жилээр Тэргүүлэгчдэд, бүтэн жилээр хурлын хуралдаанд мэдээлж ажиллахыг сумын Засаг дарга /И.Баасанжав/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Н.ЖАРГАЛСАЙХАН

Орхон аймгийн Баян-Өндөр сумын ИТХ-ын
2014 оны 12 сарын 30 өдрийн ээлжит XIV хуралдааны
02-р тогтоолын 01-р хавсралт

ИРГЭНД ЭЗЭМШИЖ БАЙГАА ХАШААНЫ ГАЗРЫГ НЬ ҮНЭГҮЙ ӨМЧЛҮҮЛЭХ ГАЗРЫН БАЙРШИЛ, ХЭМЖЭЭ

№	Багийн нэр	Байршил буюу хаяг	Байршлын солбицол	Өрхийн тоо	Газрын хэмжээ / га /	Хэрэгжүүлэх хугацаа /улирлаар/				Хариуцах эзэн
						I	II	III	IV	
1	Баянбулаг			24	2.4					Сумын Засаг дарга, Газрын даамал, Аймгийн газрын албаны холбогдох мэргэжилтэн
2	Булаг			15	1,5					
3	Цагаанчулуут			20	2					
4	Рашаант			20	2					
5	Наран			20	2					
6	Шанд			15	1,5					
7	Их залуу			30	2,4					
8	Дэнж			25	2					
9	Эрдэнэ			120	9					
10	Говил			56	4.48					
11	Баянцагаан			25	2					

ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ЭМХТГЭЛ | 2014

12	Яргуйт			160	12					
13	Даваат			70	5,25					
14	Уртын гол			20	2,5					
15	Хүрэнбулаг			55	1,5					
Дүн				705	52,53					

Орхон аймгийн Баян-Өндөр сумын ИТХ-ын
2014 оны 12 сарын 30 өдрийн ээлжит XIV хуралдааны
02-р тогтоолын 02-р хавсралт

**ИРГЭНД ГЭР БҮЛИЙН ХАМТЫН ХЭРЭГЦЭЭНД ЗОРИУЛАН ШИНЭЭР ЭЗЭМШҮҮЛЭХ
ГАЗРЫН БАЙРШИЛ, ХЭМЖЭЭ**

№	Багийн нэр	Байршил	Байршлын солбицол	Өрхийн тоо	Газрын хэмжээ /м² /	Зориулалт	Хэрэгжүүлэх хугацаа /улирал, сараар/												Хариуцах эзэн
							I			II			III			IV			
							1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	
1	Говил	Ар булаг		5	0,3	Гэр бүлийн хэрэгцээ /зуслан/												Сумын Засаг дарга, Газрын Даамал	
2	Говил	Ар булаг		74	4,4	Гэр бүлийн хэрэгцээ /зуслан/												Сумын Засаг дарга, Газрын Даамал	
3	Говил	Баянцагаан		84	5.04	Гэр бүлийн хэрэгцээ /зуслан/												Сумын Засаг дарга, Газрын Даамал	
4	Яргуйт баг	Хөтөл хэсэг		72	5,4	Гэр бүлийн хэрэгцээ												Сумын Засаг дарга, Газрын Даамал	

Тайлбар: Зуслангийн зориулалтаар олгох газрын хэмжээг 20*30-600м2 байхаар тооцооллоо.

Орхон аймгийн Баян-Өндөр сумын ИТХ-ын
2014 оны 12 сарын 30 өдрийн ээлжит XIV хуралдааны
02-р тогтоолын 03-р хавсралт

2015 ОНД ИРГЭНД ГЭР БҮЛИЙН ХЭРЭГЦЭЭНИЙ ЗОРИУЛАЛТААР НӨХӨН ЭЗЭМШҮҮЛЭХ ГАЗРЫН БАЙРШИЛ, ХЭМЖЭЭ, ЗОРИУЛАЛТ

№	Сумын нэр	Багийн нэр	Байршил буюу хаяг	Эзэмшүүлэх гарзын хэмжээ /га /	Өрхийн тоо	Газрын хэмжээ /га /	Хэрэгжүүлэх хугацаа /улирлаар/				Хариуцах эзэн
							I	II	III	IV	
1	Баян-Өндөр	Яргуйт	Хөтөл хэсэг	0,075	516	38,7					ГХБХБГ, Сумын Засаг дарга, Газрын даамал
2		Эрдэнэ	Чингэлийн хэсэг	0,075	100	7.5					
	Дүн				616	46,2					

Орхон аймгийн Баян-Өндөр сумын ИТХ-ын
2014 оны 12 сарын 30 өдрийн ээлжит XIV хуралдааны
02-р тогтоолын 04-р хавсралт

ХУУЛЬ БУС ГАЗАР ЭЗЭМШИЛТИЙН ТАЛААР АВАХ АРГА ХЭМЖЭЭ

№	Багийн нэр	Байршил	Талбайн солбицол	Зөвшөөрөлгүй газрын хэмжээ /М ² /	Авах арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа												Хариуцах эзэн
						/улирал, сараар/												
						I			II			III			IV			
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12							
1	Эрдэнэ	Жаргалант хэсэг		20 нэгж талбар	Албадан буулгалт хийх											Сумын Засаг дарга, Багийн Засаг дарга Мэргэжлийн хяналтын газар, Газрын даамал		
2	Дэнж	Нарлаг дэнж хэсэг		10 нэгж талбар	Албадан буулгалт хийх											Сумын Засаг дарга, Багийн Засаг дарга Мэргэжлийн хяналтын газар, Газрын даамал		
3	Яргуйт	Овоот хэсэг		20 нэгж талбар	Албадан буулгалт хийх											Сумын Засаг дарга, Багийн Засаг дарга Мэргэжлийн хяналтын газар, Газрын даамал		

ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ЭМХТГЭЛ | 2014

4	Уртын гол	Баянталын хэсэг		5 нэгж талбар	Албадан буулгалт хийх											Сумын Засаг дарга, Багийн Засаг дарга Мэргэжлийн хяналтын газар, Газрын даамал
5	Баянбулаг	Тоглоомын талбайн урд хэсэг		10 нэгж талбар	Албадан буулгалт хийх											Сумын Засаг дарга, Багийн Засаг дарга Мэргэжлийн хяналтын газар, Газрын даамал
Дүн																



ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 6 ДАХЬ УДААГИЙН
СОНГУУЛИЙН ЭЭЛЖИТ XIV ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2014 оны 12 сарын 30 өдөр

Дугаар 03

Эрдэнэт

Сумын амьжиргааг дэмжих зөвлөлөөс
2014 онд зохион байгуулсан ажилд үнэлэлт өгөх тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1, Нийгмийн Халамжийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.6 дахь заалт, Сумын амьжиргааг дэмжих зөвлөлийн даргын мэдээллийг ээлжит XIV хуралдаанаар хэлэлцээд ТОГТООХ нь:

1.Сумын Амьжиргааг дэмжих зөвлөлөөс 2014 онд зохион байгуулсан ажлыг ХАНГАЛТТАЙ гэж дүгнэсүгэй.

2.Нийгмийн халамжийн тухай хуулийг хэрэгжүүлэн, багуудын Амьжиргааг дэмжих зөвлөлийг өдөр тутмын удирдлагаар хангаж, хэрэгжилтийг хагас жилээр Тэргүүлэгчдэд, бүтэн жилээр хурлын хуралдаанд мэдээлж ажиллахыг сумын Засаг даргын тамгын газрын дарга, Амьжиргааг дэмжих зөвлөлийн дарга /М.Эрдэнэчимэг/-т үүрэг болгосугай.

ДАРГА

Н.ЖАРГАЛСАЙХАН



ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 6 ДАХЬ УДААГИЙН
СОНГУУЛИЙН ЭЭЛЖИТ XIV ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2014 оны 12 сарын 30 өдөр

Дугаар 04

Эрдэнэт

Байгаль орчныг хамгаалах ажлын
2014 оны ажлын хэрэгжилтэд үнэлэлт өгөх тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйл, сумын Байгаль орчны улсын байцаагчийн мэдээллийг ээлжит XIV хуралдаанаар хэлэлцээд ТОГТООХ нь:

1.Сумын нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, түүний баялагийг зохистой ашиглах, нөхөн сэргээх ажлын хэрэгжилтийг ХАНГАЛТГҮЙ гэж дүгнэсүгэй.

2.Сумын нутаг дэвсгэрт Байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, хагас жилээр тэргүүлэгчдийн хуралдаанд, бүтэн жилээр хурлын хуралдаанд танилцуулахыг сумын Засаг дарга /И.Баасанжав/, Байгаль орчны улсын байцаагч /Б.Алтаншагай/ нарт үүрэг болгосугай.

ДАРГА

Н.ЖАРГАЛСАЙХАН



ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 6 ДАХЬ УДААГИЙН
СОНГУУЛИЙН ЭЭЛЖИТ XIV ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2014 оны 12 сарын 30 өдөр

Дугаар 05

Эрдэнэт

Баян-өндөр сумын 2014 оны ОНХС-гийн
төсөвт тодотгол хийх тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.2 дахь заалт, Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2014 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 01 дүгээр тогтоолыг үндэслэн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ээлжит XIV хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Сумын ОНХС-д 2014 онд батлагдсан төсвийн зардлын хэмнэлт 19 512 430 /Арван есөн сая таван зуун арван хоёр мянга дөрвөн зуун гучин/ төгрөг, зураг төсвийн зардлын үлдэгдэл 252 717 370 /Хоёр зуун тавин хоёр сая долоон зуун арван долоон мянга гурван зуун далан/ төгрөг, нийт 272 238 800 /Хоёр зуун далан хоёр сая хоёр зуун гучин найман мянга найман зуун/ төгрөгийг аймгийн Орон нутгийн хөгжлийн санд төвлөрүүлэн шилжүүлсүгэй.

2.2014 оны төсвийн жилд Орон нутгийн хөгжлийн сангаас 272 238 800 /Хоёр зуун далан хоёр сая хоёр зуун гучин найман мянга найман зуун/ төгрөгийг орон нутгийн орлогод төвлөрүүлэхийг Сумын Засаг дарга /И.Баасанжав/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА

Н.ЖАРГАЛСАЙХАН



**ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 6 ДАХЬ УДААГИЙН
СОНГУУЛИЙН ЭЭЛЖИТ ХІV ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2014 оны 12 сарын 30 өдөр

Дугаар 06

Эрдэнэт

ИТХ-ын үйл ажиллагааны 2014 оны
төлөвлөгөөний биелэлтэд үнэлэлт өгөх тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1 дэх заалт, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөвлөгөөний биелэлтийн тухай ИТХ-ын даргын илтгэлийг хэлэлцээд ТОГТООХ нь:

1.Сумын ИТХ-ын үйл ажиллагааны 2014 оны төлөвлөгөөний биелэлтийг төлөөлөгчдийн олонхийн саналаар ХАНГАЛТТАЙ гэж дүгнэсүгэй.

ДАРГА

Н.ЖАРГАЛСАЙХАН



**ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 6 ДАХЬ УДААГИЙН
СОНГУУЛИЙН ЭЭЛЖИТ ХІV ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2014 оны 12 сарын 30 өдөр

Дугаар 07

Эрдэнэт

**ИТХ-ын үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх 2015 оны
үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах тухай**

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1, 18 дугаар зүйлийн 18.1.2 дахь заалт, 2015 онд ИТХ-ын үндсэн чиглэлийн төслийг хуралдаанаар хэлэлцээд ТОГТООХ нь:

1.ИТХ-ын үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх 2015 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2.Төлөвлөгөөг хэрэгжүүлэх, удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг хурлын нарийн бичгийн дарга /З.Эрдэнээ/, Хороодын дарга нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА

Н.ЖАРГАЛСАЙХАН

Баян-Өндөр сумын ИТХ-ын 2014 оны
12 дугаар сарын 30ны өдрийн XIV хуралдааны
01 дугаар тогтоолын хавсралт

**БАЯН-ӨНДӨР СУМЫН ИТХ-ЫН ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2015 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

2014 он
Эрдэнэт

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Гүйцэтгэлийн шалгуур			Хариуцах албан тушаалтан
		Арга хэмжээ /гарц/-ний шалгуур үзүүлэлт /тоо, чанар, хугацаа/-ний хүрэх түвшин	Хугацаа	Хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн хүрэх түвшин	
Нэг. Хууль зүй, хурал, захиргааны бодлого хэрэгжилтийн чиглэлээр					
1	1.1.Хурлын байгууллагын бүтэц тогтолцоог оновчтой зохион байгуулж, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Тэргүүлэгчид, хурлын хороо, хурал дахь намын бүлгүүд, Төлөөлөгчид, Ажлын албаны тасралтгүй үйл ажиллагаа явуулах боломжийг хангаж, нутаг дэвсгэрийн хэмжээний эдийн засаг, нийгмийн асуудлыг бие дааж шийдвэрлэнэ.	1.1.1.2015 оныг “ISO 9001 Чанарын удирдлагын стандартыг сумын ЗДТГ, багуудад нэвтрүүлэх жил болгох” зорилт дэвшүүлэх	Жилдээ	Төлөвлөгөө гаргаж бүрэн хэрэгжүүлнэ.	ИТХ-ын дарга Тэргүүлэгчид, ХЗХЗБХХ
		1.1.2.Шийдлийн Засгийн газраас дэвшүүлсэн зорилт, хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллах	Жилдээ	Хэрэгжилтийг бүрэн хангана	ИТХ-ын дарга, ажлын алба, Хороод
		1.1.3. Сумын ЗДТГ-ын ажиллагсдын ажил үүргийн хуваарь, ажлын байрны тодорхойлолтыг сайжруулах ажлыг судлах, чиглэлэ өгөх	Жилдээ	Ажил үүргийн давхардлыг арилгана.	ИТХ-ын дарга ХЗХЗБХХ
2	1.2.Төлөөлөгчдийн төр захиргааны болон эрх зүйн боловсролыг дээшлүүлэх зорилгоор сургалт семинарт хамруулж, гаргасан санал, санаачилгыг бүх талаар нь дэмжин, сонгогдсон тойрогтоо Аймгийн ИТХ-ын Төлөөлөгчидтэй хамтран	1.2.1.Төлөөлөгчдийн дунд явуулах сургалтын төлөвлөгөө боловсруулан НУХ, АИТХ-тай хамтран сургалтад хамруулах	Улирал бүр	Төлөвлөгөө гаргаж бүрэн хэрэгжүүлнэ.	ИТХ-ын дарга, ажлын алба, ХЗХЗБХХ
		1.2.2.Төлөөлөгчдөөс тойрогт хэрэгжүүлэхээр гаргасан санал санаачилгыг хөтөлбөр төлөвлөгөөнд тусгах, Аймгийн ИТХ-ын төлөөлөгчид	Жилдээ	Мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтийг хангана.	ИТХ-ын ажлын алба, ХЗХЗБХХ, ЗДТГ

ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ЭМХТГЭЛ | 2014

	ажиллах бололцоог бүрдүүлэн ажиллана.	холбогдох байгууллага албан тушаалтанд уламжилж, хамтран ажиллах нөхцөл бүрдүүлэх			
3	1.3. Сумын ИТХ, Тэргүүлэгчид, хурлын хороод, ажлын алба, Сумын Засаг дарга, ЗДТГ-ын хоорондын хамтын ажиллагаа, уялдаа холбоог сайжруулна.	1.3.1.Сумын ИТХ-ын хуралдаан тэргүүлэгчидийн хурлаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөө гаргаж бэлтгэл ажлыг хангах	Жилдээ	Журам төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлнэ.	ИТХ-ын дарга, ажлын алба
		1.3.2.Хурлын хороодоос зохион байгуулах ажлын төлөвлөгөөг Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлэн баталж, хэрэгжилтэд хяналт тавих	Улирал бүр	Төлөвлөсөн ажлыг бүрэн хэрэгжүүлсэн байна.	ИТХ-ын дарга Тэргүүлэгчид, Хороодын дарга нар
		1.3.3.Хурлын хороо, төлөөлөгч нарын оролцоог дүгнэх үзүүлэлт боловсруулж үнэлгээ өгөх	Улирал бүр	Журам боловсруулан ажиллана.	ИТХ-ын дарга, ажлын алба, ХЗХЗБХХ
		1.3.4.Сумын ЗДТГ, багуудын үйл ажиллагаатай танилцах, үнэлэлт дүгнэлтийг, Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрийг хүргүүлэх	Хуваа-рийн дагуу	ЗДТГ, багуудын ажлын үр дүн сайжирсан байна.	ИТХ-ын дарга, Тэргүүлэгчид
4	1.4. Засаг даргын мөрийн хөтөлбөр болон нутаг дэвсгэрийг хөгжүүлэхэд чиглэгдсэн урт богино хугацааны хөтөлбөр төлөвлөгөөг хэтийн зорилттой уялдуулан баталж, хэрэгжүүлэх ажилд бүх талын дэмжлэг үзүүлж ажиллана.	1.4.1.Сумын эдийн засаг нийгмийг 2015 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг тухайн жилийн зорилттой уялдуулан хуралдаанаар хэлэлцэж батлах, үнэлэлт дүгнэлт өгөх	Хагас бүтэн жилээр	Төлөвлөсөн ажлыг бүрэн хэрэгжүүлсэн байна.	ИТХ-ын дарга, Төлөөлөгчид
		1.4.2 2015онд хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл арга хэмжээг хуралдаанаар хэлэлцэж батлах	Хагас бүтэн жилээр	Тулгамдсан асуудлыг иргэдийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан бодитой төлөвлөсөн байна.	ИТХ-ын дарга, Төлөөлөгчид
		1.4.3.Хөтөлбөр төсөл арга хэмжээний биелэлт, үр дүнд хяналт тавих, Засаг даргын мэдээллийг хуралдаанаар хэлэлцүүлэн, шийдвэрийг хүргүүлэх	Хагас бүтэн жилээр	Төлөвлөсөн хөтөлбөр, төсөл, арга хэмжээ 100% хэрэгжсэн байна.	ИТХ-ын дарга, Төлөөлөгчид, ажлын алба
5	1.5. Сумын ИТХ-ын үйл	1.5.1. Хурлын хороо, зөвлөл ажлын	Улирал	Хууль журмын	ИТХ-ын

ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ЭМХТГЭЛ | 2014

	ажиллагаанд мөрдөх журмуудыг шинэчлэн боловсруулж, хурлын үйл ажиллагааг боловсронгуй болгоно.	хэсгүүдийн төлөвлөгөө, удирдамж, ажиллах журмуудыг тухай бүр боловсруулж, Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцэн баталж мөрдүүлэх	бүр	дагуу боловсруулагдсан байна.	Төлөөлөгчид, Хурлын ажлын алба, ХЗХЗБХХ
		1.5.2.Багийн ИНХ-уудыг ажлын өрөөтэй болгож, өдөр тутмын удирдлагаар ханган ажлыг сайжруулах	Жилдээ	ИНХ-ын дотоод үйл ажиллагаа сайжирна.	ИТХ-ын дарга, ажлын алба, ХЗХЗБХХ
6	1.6. Хурлын болон ЗДТГ-ын ажлын ил тод байдлыг хангаж, цахимжуулах иргэдэд мэдээллийг нээлттэй хүргэх талаар хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллана.	1.6.1.Веб сайтаар хурлын болон ажлын албаны үйл ажиллагаа, төсвийн гүйцэтгэлийг тайлагнах, төлөөлөгч нарыг iPad ашиглуулан хуралдааны материал хүргэх	Сар бүр	Иргэдэд мэдээллийг нээлттэй байлгана.	ИТХ-ын дарга, ажлын алба
		1.6.2.Хурлын хуралдаан, Тэргүүлэгчдийн хурлыг цахимаар болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах талаар хамтран ажиллах	Сар бүр	Иргэдэд мэдээллийг нээлттэй байлгана.	ИТХ-ын дарга, ажлын алба
		1.6.3.Төлөөлөгчдийг хууль эрх зүйн болон бусад мэдээллээр хангах	Байнга	Төлөөлөгчдийн мэдлэг чадварыг сайжруулсан байна.	ИТХ-ын ажлын алба, ХЗХЗБХХ
7	1.7. Сумын эдийн засаг, нийгмийн асуудлыг бие даан шийдвэрлэх бодлогын хүрээнд Сумын ИТХ-ын Тэргүүлэгчид, Хороод, хурал дахь намын бүлгүүд, Төлөөлөгчдөд иргэдээс ирүүлсэн санал хүсэлт, өргөдөл гомдлыг судлан, дүгнэж оновчтой шийдвэрлэж хариу өгөн, биелэлтэд хяналт тавьж ажиллана.	1.7.1.ИТХ-д болон Төлөөлөгч нарт иргэдээс ирүүлэх санал хүсэлт, өргөдөл гомдлыг хүлээн авах, шийдвэрлэж хариу өгөх	Сар бүр	Хууль журмыг дагаж мөрдүүлнэ.	ИТХ-ын Төлөөлөгчид, Хурлын ажлын алба
		1.7.2.Төрийн болон байгууллага ААН-ээс зохион байгуулсан өдөрлөг бусад арга хэмжээнд төлөөлөгчдийг оролцуулах, тэндээс гарсан санал хүсэлтийг шийдвэрлүүлж хариу өгөх	Жилдээ	Төлөөлөгчдийн ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ.	ИТХ –ын дарга,ажлын алба
8	1.8. Бүх шатанд иргэний танхим нээн ажиллуулж аливаа шийдвэрийг гаргахаасаа өмнө олон нийтэд мэдээлдэг, тэдний санаа бодлыг	1.8.1.Сум, багуудын Иргэний танхимыг байнгын үйл ажиллагаатай болгох, иргэдэд мэдээлэл авах, санал хүсэлт илэрхийлэх нөхцөл бүрдүүлэх	Жилдээ	Иргэдэд үйлчилгээг ойртуулна.	ИТХ-ын Төлөөлөгчид, Хурлын ажлын алба

ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ЭМХТГЭЛ | 2014

	судалж, хүлээн авдаг, оролцуулдаг, гаргасан шийдвэрийг нийтэд ил тод мэдээлдэг, иргэний оролцооны ардчилсан соёлыг нэвтрүүлнэ.	1.8.2.Сум, багийн нутаг дэвсгэрт хэрэгжүүлэх хөтөлбөр, төслийг иргэдээр хэлэлцүүлэн төлөөлөгчдийн саналыг тусган эрэмбэлж, хуралдаанаар батлах	Жилдээ	Эрэмбэлэгдсэн ажил арга хэмжээг бүрэн хэрэгжүүлнэ.	ИТХ-ын дарга, төлөөлөгчид
9	1.9. Орон нутгийн онцлог, байршил, хүн ам зүйн бодлогод тохирсон дүрэм журмуудыг иргэдийн оролцоотой боловсруулан баталж, дагаж мөрдүүлэх ажлыг эрчимтэй зохион байгуулна.	1.9.1.Нийтээр дагаж мөрдүүлэхээр ИТХ-ын хуралдаан, Тэргүүлэгчдийн тогтоол, шийдвэр, журам боловсруулж мөрдөх	Улирал бүр	Хууль зүйд нийцсэн байна.	ИТХ-ын Төлөөлөгчид, Хурлын ажлын алба
		1.9.2 Хурлаас нийтээр дагаж мөрдүүлэхээр гаргасан шийдвэрт биелэлт хяналт тавьж тооцох	Улирал бүр	Журмуудыг дагаж мөрдүүлнэ.	ИТХ-ын дарга, ажлын алба, Төлөөлөгчид, ЗДТГ
10	1.10. Төрийн үйлчилгээний байгууллагуудын менежментийг сайжруулах бодлогыг дэмжиж, захиалгат аудит тогтмол хийлгэн, иргэдээс байнга шүүмжлэлт өртөж байгаа байгууллага, алба хаагчдын үйл ажиллагаанд тэдний эрх ашгийн үүднээс үнэлэлт дүгнэлт өгч хяналт тавих тогтолцоог бий болгоно.	1.10.1.Төрийн болон ТББ, ӨЭМТөв, Цагдаагийн хэсэг, СӨХ-дын ажилд хяналт тавьж, удирдлагуудын мэдээлэл сонсох	Жилдээ	Ажил сайжирсан байна.	ИТХ-ын дарга Тэргүүлэгчид, Хороод
		1.10.2.Сумын ЗДТГ-ын үйл ажиллагаанд олон улсын чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлж үйлчилгээний стандарт тогтоож мөрдөх	Жилдээ	Стандарт нэвтрүүлсэн гэрчилгээ олгоно.	ИТХ-ын дарга Тэргүүлэгчид, Хороод
		1.10.3.Төлөөлөгчдийг ААН байгууллагын ажилтай танилцах боломжоор ханган мэдээллийг Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцэх	Жилдээ	Ажил сайжирна.	ИТХ-ын дарга Тэргүүлэгчид, Хороод
11	1.11. Сумын ЗДТГ, багуудын бүтэц орон тоо, ажил үүргийн хуваарилалт, ажлын уялдаа холбоог сайжруулах, хүний нөөц, ажилтнуудын мэдлэг ур чадвар хариуцлагыг дээшлүүлэх удирдлага зохион байгуулалтын арга хэмжээг хэрэгжүүлнэ.	1.11.1.Сумын ЗДТГ, багууд, ТЗАХ-дын ажиллах нөхцөл нийгмийн баталгааг хангах талаар ЗДТГ-ын даргын мэдээлэл сонсох	II улиралд	Ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ	ИТХ-ын дарга Тэргүүлэгчид
		1.11.2.ТЗАХ-д багийн Засаг дарга нарын ажлын мэдээлэл сонсох хуваарь гарган Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлэх	Хуваарийн дагуу	Ажилчдын мэдлэг чадвар дээшилсэн байна.	ИТХ-ын дарга Тэргүүлэгчид

ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ЭМХТГЭЛ | 2014

12	1.12. Статистик мэдээллийн үнэ цэнийг өсгөж, удирдлагын хэрэгсэл болгон ажиллах нөхцөл бүрдүүлж ажиллахын зэрэгцээ ил тод байдал, хамрах хүрээг нэмэгдүүлнэ.	1.12.1.Статистик мэдээллийг нэгтгэж гаргуулах ААНБ, иргэдийг хамруулах талаар хийсэн ажлын мэдээлэл сонсон, үнэн зөв гаргах, мэдээг ашиглах явцад хяналт тавих	Жилдээ	Төлөөлөгчдийн мэдээллээр бүрэн хангана.	ИНХ-ын ажлын алба
13	1.13. Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын эрх зүйн үндэс болсон хууль тогтоомж, Улсын Их Хурал, Засгийн газар, аймгийн ИТХ-аас гарсан тогтоол шийдвэрийг удирдлага болгон ажилдаа тусгаж, хуулийн төсөл, УИХ, Засгийн газрын бодлого шийдвэрт сумын нутаг дэвсгэрт тулгамдсан тодорхой асуудлуудыг тусгахад онцгой анхаарна.	1.13.1.Хууль тогтоомж, Засгийн газар, Аймгийн ИТХ-ын тогтоолын хурлын байгууллагад хамаарах заалтыг хяналтад авах, биелэлт тооцох	Жилдээ	Биелэлтийг бүрэн ханган ажиллана.	ИТХ-ын дарга, Тэргүүлэгчид, төлөөлөгчид
		1.13.2.Хуулийн төсөл, нутаг дэвсгэрийн тулгамдсан асуудлаар хэлэлцүүлэг, санал асуулга явуулж, дүнг дээд байгууллагад уламжлах	Жилдээ	Төсөл саналыг оновчтой боловсруулна.	ИТХ-ын дарга, Тэргүүлэгчид, төлөөлөгчид
14	1.14. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг бүх нийтийн үйл хэрэг болгох, хүүхэд залуучуудад төрийн хуулийг хүндэтгэх, сахин биелүүлэх сэтгэлгээг төлөвшүүлэх, хэв журам сахиулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр гаргасан хөтөлбөрүүдийг төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулж, гэмт хэрэгтэй тэмцдэг олон улсын туршлага, дэвшилтэт арга барилыг нэвтрүүлж, сургалт, сурталчилгааны ажлыг эрчимжүүлнэ.	1.14.1.ИТХ, ЗДТГ, багуудын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх гурвалсан гэрээний явцад хяналт тавьж зөвлөмж өгөх,БЗД нарын мэдээлэл сонсох	Улирал бүр	Гэмт хэрэг зөрчил буурсан байна.	Төлөөлөгчид, ГХУСЗ-ийн гишүүд
		1.14.2.Нийгмийн дэг журмыг сахиулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар гарсан хууль, хөтөлбөр төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах	Улирал бүр	Гэмт хэрэг зөрчил буурсан байна.	Төлөөлөгчид, Багийн Засаг дарга нар, Цагдаагийн хэсэг
		1.14.3 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг үр дүнтэй зохион байгуулсан байгууллага ААН-ийг сурталчлах шагнаж урамшуулах	4 улиралд	Гэмт хэрэг зөрчил буурсан байна.	ИТХ –ын дарга ажлын алба
15	1.15. Гамшгаас хамгаалах урьдчилан сэргийлэх, болзошгүй гамшиг ослын хор уршгийг арилгах, сэргээн босгох нөөц санг бүрдүүлэх,	1.15.1.Хүн малын гоц халдварт өвчин болон байгалийн гамшиг ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих	Жилдээ	Нөлөөллийг бууруулсан байна.	Тэргүүлэгчид, Хурлын ажлын алба

ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ЭМХТГЭЛ | 2014

	үйлдвэрлэлийн ослын нөлөөллийг бууруулах ажлыг эрчимжүүлнэ.	1.15.2. Осол аюул гарах эрсдэлт байдалд үнэлгээ хийж засаг даргад чиглэл өгөх	Жилдээ	Осол зөрчлийн гаралтыг бууруулна.	ИТХ-ын дарга, Тэргүүлэгчид
Хоёр. Төсөв санхүү, хөрөнгө оруулалтын чиглэлээр					
16	2.1. Сумын төсвийн орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлж, орон нутгийн төсөв, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг хөгжлийн тэргүүлэх чиглэлд оновчтой хуваарилах, хөрөнгө оруулалтын үр ашгийн дээшлүүлэх, хүн амын орлого, нийгмийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх бодлого баримтална.	2.1.1.Сумын ИТХ-ын ажлын алба, ЗДТГ, багуудын төсвийг хянаж батлах зарцуулалт, гүйцэтгэлд хяналт тавих, хуралдаанаар хэлэлцэх	Улирал бүр	Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлнэ.	Төлөөлөгчид, ТСХОБ хороо
		2.1.2.ОНХС-ийн хөрөнгөөр гүйцэтгэх хөтөлбөр, төсөл арга хэмжээг оновчтой тодорхойлох, хэрэгжилтэнд иргэдийн оролцоотой хяналт тавих, тодотголыг хурлаар хэлэлцэх	Хагас бүтэн жилээр	Баг тус бүрээр хэлэлцүүлэг явуулна.	Ажлын хэсэг БИНХ
17	2.2. Орон нутгийн өмч хөрөнгийн өмчлөгчийн эрхийг хэрэгжүүлэх, нийтийн эзэмшлийн зориулалттай эд хөрөнгийг бүртгэх, хууль тогтоомжид заасан эрхийн дагуу түүнийг эзэмших, ашиглах, захиран зарцуулалтанд хяналт тавьж ажиллана.	2.2.1.ЗДТГ, багуудын өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт хамгаалалт, эд хөрөнгийн тооллого бүртгэлд үнэлгээ хийх	Хагас бүтэн жилээр	Хөрөнгө оруулалтын ажлыг чанартай гүйцэтгүүлнэ.	БИНХ
		2.2.2.Нийтийн эзэмшлийн эд хөрөнгийн эзэмшигчийг тодорхойлох,хадгалалт хамгаалалт ашиглалтанд хяналт тавих	Хагас бүтэн жилээр	бүрэн бүтэн байдлыг хангана	Ажлын хэсэг ТСХОБ хороо
